

MONGOLIAN ECONOMY

2014 ОНЫ 9 САР. №15 (073)

PPP

ТҮНШЛЭЛИЙН ТУРШЛАГА

ЭДИЙН ЗАСАГ

ӨНДӨР БОСГЫГ ДАВАХЫН ТУЛД

УУЛ УУРХАЙ

ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ БАЙРАА
ЗАСЛАА

PPP-БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МӨРӨӨДӨЛ





Миний амьдрал шилдгүүдийн өрсөлдөөн дунд өрнөдөг Миний карт American Express

Эрхэм та өндөр дүнтэй зээлийн эрх болон нууцлал хамгаалалт бүхий American Express Gold Card эзэмшигч болсноор олон улс болон дотоодын нэр хүнд бүхий үйлчилгээний байгууллагууд, нисэх буудлуудын вип танхимуудаар үйлчлүүлэн иж бүрэн даатгалтайгаар аялж, ажиллах боломжтой болохоос гадна гүйлгээ хийн оноо цуглуулж онцгой хөнгөлөлт урамшуулуудыг авах болно.



Дэлгэрэнгүй мэдээллийг
www.americanexpress.mn-ээс

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүмнэ



Миний амьдрал. Миний карт.



MONGOLIAN MINING DIRECTORY 2015


МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ

Монголын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх уул уурхайн компани, хөрөнгө оруулагч компани, ханган нийлүүлэлтийн болон уул уурхайн салбарт үйлчилгээ үзүүлэгч аж ахуй нэгж, төрийн болон төрийн бус бүх байгууллагын нэгдсэн мэдээллийг хүргэдэг “МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ” номыг тав дахь жилдээ эрхлэн гаргах гэж байна. Тус ном нь гадаад, дотоодын уул уурхайн компани, Олон улсын хурал үзэсгэлэн болон Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, гадаад улсад суугаа Монголын Элчин сайдын яамдаар дамжуулан хөрөнгө оруулагч нарт үнэ төлбөргүй хүргэгддэг онцлогтой.

Монголын уул уурхайн салбарынханд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хамгийн хүртээмжтэй хүргэхийг хүсч буй та бүхнийг “МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН НЭГДСЭН ЛАВЛАХ -2015” номтой хамтарч ажиллахыг урьж байна.

**МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА
БАЙРШУУЛАХ ЗАХИАЛГА
ЯВАГДАЖ БАЙНА**

70115590



Дэлгэрэнгүй мэдээллийг

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, МҮЭСТО-300 тоот

Утас: +976-70115590, Факс: +976-70125590

И-мэйл: marketing@mining.mn, book@mining.mn, Веб: www.mining.mn

Монголын сэтгүүлдийн
эвлэлийн “2013 оны
Шилдэг сэтгүүл”

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Ийланд Роберт Мэн

ЗӨВЛӨХ МЭРГЭЖИЛТЭН:

Лиззи Хүү

ВЭБ РЕДАКТОР:

Б.Энхцэцэг

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Б.Үүрийнтуяа

С.Батзаяа

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав / 9409-2904

“ЕКОНОМУ” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг.

VI хороо, Их сургуулийн гудамж.

AB center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС



Бид энэ удаагийн дугаартаа хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотой нэгэн шинэлэг сэдвийг хөндөж байна. PPP буюу төр, хувийн хэвшлийн түншлэл боловсролын салбарт хэрэгжих эхлэл тавигдаж байгааг шинэхэн дугаарынхаа онцлох сэдвээр сонголоо.

Хичээлийн шинэ жил эхэлж хүүхэд багачууд маань хүсэн хүлээсэн сургууль, цэцэрлэгтээ ороод, хөөр баяртай байгаа ч тэдний суралцаж байгаа анги танхим, сургуулийн орчин нөхцөл сэтгэл хангалуун байх

түвшинд биш. Өнөөдөр Монголын боловсролын чанар, хүүхдийн эрүүл зөв хоололт, эрүүл мэнд гээд эцэг эхийн санааг зовоох олон асуудал бий ч сургалтын орчин, сургуулийн дэд бүтэц хамгийн тулгамдсан асуудал юм. Сургуулийн өмнөх боловсролд стандартаар бол нэг бүлэгт 20 гаруй хүүхэд байх ёстой ч өнөөдөр 50, 60-уулаа шахцалддаг нь энгийн үзэгдэл болсон. Хэл мэдэхгүй жаахан амьтад хэрхэн хоол ундаа идэж, хэвтэж унтдагийг нь төсөөлөхөд ч бэрх. Сургуулийн босго алхаад ч тэдний амьсгалах агаар, суух талбай нэмэгдэхгүй нь хармсалтай. Сургуулийн барилгын хүрэлцээ муу, нийслэлийн хүн амын төвлөрлөөс болоод Улаанбаатарт улсын сургуулийн анги дүүргэлт хотын захад ч, төвийн дүүрэгт ч мөн л 40, 50-иас шалтай буурахгүй байх жишээтэй. Гаднын болон дотоодын хөрөнгө оруулалттай хувийн бага, дунд сургууль олширсон болохоор орчин нөхцөл сайтай сургууль цөөнгүй бий. Гэхдээ жилийн хэдэн мянган ам.доллараар үнэлэгдэх төлбөртэй хувийн сургуулиудад үр хүүхдээ сургах гэр бүлийн тоо тийм ч олон биш. Ёстой нөгөө “Санаа байгаад сачий хүрэхгүй” гэдэг л болох нь тэр.

Гэтэл XXI зууны монгол иргэн дэлхийн стандартад нийцсэн орчинд сурч боловсрох эрхтэй. Энэ бол төрийн нэг үүрэг юм. Тэгвэл төр энэ үүргээ биелүүлэхийн тулд хувийн хэвшилтэй хамтрах шаардлага гарч, PPP хэрэгжүүлэх ажил эхэлж байгаа нь олзуурхууштай зүйл. Тиймээс боловсролын салбарт тэр дундаа сургуулийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр PPP хэрэгжүүлэх боломж нөхцөл, шаардлага нь манайд ямар байгаа, хоёр талдаа цаашид юуг анхаарах, гаднын туршлага ямар байдаг, ногоон барилгын стандарт юу байх вэ гэх зэрэг сэдвийн хүрээнд хөндлөө. Монголд PPP хэрэгжүүлсэн туршлага бага учраас цаашид илүү сайжруулж авч явах тэр дундаа боловсролын салбарын дэд бүтцийн асуудлыг хамтран шийдвэрлэхээр зориг шулуудаж, зорилго нэгдсэн төр, хувийн хэвшлийнхэнд баяр хүргэе. Боловсролын салбар учраас аль аль нь алдах эрхгүй.

Бидний ирээдүй хойч болсон хүүхэд багачуудын маань сурах орчин нөхцөл аюулгүй, ая тухтай, сайн байх ёстой.

Орлогч эрхлэгч И.ОТГОНЖАРГАЛ

ОНЛАЙН СЭТГҮҮЛ
mongolianeconomy.imedia.mn



facebook.com/MongolianEconomy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy

АГУУЛГА

PPP

- 6 Дээс томж найзыгаа аваръя
- 9 “Mongolian economy” сэтгүүлийн асуулт
- 10 Түншлэлийн туршлага
- 12 Хойч үедээ зориулах хөрөнгө оруулалт

ЭДИЙН ЗАСАГ

- 14 Өндөр босгыг давахын тулд
- 17 Н.Энхбаяр: уналтыг сааруулж буй салбарыг бодлогоор дэмжих ёстой
- 22 Төгрөгийн өгөөж
- 24 “Чингис бонд”-ын зарцуулалт
- 26 Тулгын гурван чулуу байраа заслаа
- 28 Монголын банкны зах зээл ба банкуудын стратеги
- 30 “Өнөөдөр бохирдуулаад, маргааш нь цэвэрлэчихээр баян биш”
- 34 Агентлагуудын бүтэц
- 36 Цалин хөлсний ялгавартай байдлыг тооцох асуудалд
- 38 Орчин үеийн улс төрийн намуудын хөгжлийн хандлага

“MONGOLIAN

ECONOMY”

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал



РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

- “Интер ном”
- “Цэцэг төв”
- “Минж плаза”
- “Алтантүлхүүр” номын дэлгүүр
- “Номин” супермаркетийн бүх салбар

- “Макс” супермаркетийн бүх салбар
- “Фреско” супермаркет
- BTSI супермаркет
- “Аз орчлон” номын дэлгүүр
- “Билэг” их дэлгүүрийн номын тасаг
- “Гранд Плаза” дахь супермаркет

- “Мир” номын дэлгүүрийн
- “Grand plaza”
- “Metro mall”
- “Sky” супермаркет
- “Улаанбаатар” их дэлгүүр
- “Max mall” дэх салбарууд

ДЭЭС ТОМЖ НАЙЗЫГАА АВАРЪЯ



Б.ҮҮРИЙНТУЯА

Төр түмний “дээр” байсан цаг улирч төр түмнийхээ тус дэмээр хөгжлийн зүг урагшлах болов. Дэлхийн томоохон гүрнүүд үүнийг хэднийнэ ойлгож, чамгүй их туршлага хуримтлуулан үлгэр жишээ болоод буй. Нэг нь нийтийнхээ төлөө нийт нь нэгнийхээ төлөө гэх зарчмаар төр хувийн хэвшилтэй хамтарч ажиллах үйл явцаа “Түншлэл” хэмээн нэрийдэж Public Private Partnership (PPP) буюу төр, хувийн хэвшлийн түншлэл гэх тодорхойлолт гарсан.

Төр, хувийн хэвшлийн түншлэл гэдэг ойлголт гэнэт гарч ирээгүй. Харин өнөө цагт энэхүү ойлголтыг өргөн хүрээнд түгээх, хэрэгжүүлэх шаардлага илүү тулгарч байгаа нь эл нэршлийн амтай бүхний ярианы сэдэв болгож байна. Эрүүл мэнд, зам тээвэр гээд

бүхий л салбарт хэрэгжих боломж бүхий энэ төрлийн түншлэл манай улсад төдийлөн дэлгэрээгүй ч алхам алхмаар ахиж байна.

Иргэдээ эрүүл байлгах, зохих ёсны боловсрол эзэмших орчин, боломжоор хангах нь төрийн үүрэг. Гэвч манай орны хувьд төрийн үүрэгт ажлын биелэлт учир дутагдалтай байгааг хэн хүнгүй мэддэг.

Боловсролын асуудал тухайн улсын эдийн засаг, улс төр, нийгмийн хөгжилтэй шууд хамааралтай оршдог гэх. Боловсролын хангамж, хүртээмж өндөртэй орнуудын ядуурлын түвшин илт бага байдгаас гадна иргэд улс төр, нийгмийн үйл ажиллагаанд оролцохдоо илүү ул суурьтай ханддаг болохыг салбарын олон байгууллага дуу нэгтэй сануулдаг. Ийм ч учраас дэлхийн томоохон орнуудын Засгийн

газрууд боловсролын салбартаа хөрөнгө харамгүй хаяхыг хичээдэг. Гэвч хүрэлцээ, шаардлагыг хангах асуудал ямар ч орны Засгийн газрын хувьд нарийн ажиллагаа, төлөвлөлт шаардах хүнд шалгуур болдог.

Найзлах шалтгаан

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод”-д нийгмийн салбарын, дэд бүтцийн салбарын түншлэл гэсэн төрөлтэй байна хэмээн заажээ.

Тэгвэл нийгмийн салбарын томоохон хэсэг болох боловсролын салбарт суралцагсдын тоо жил ирэх тусам өсөж байгааг хүүхдүүдээ бүртгүүлэхээр цэцэрлэгийн хаалга сахих эсвэл бага ангийн хүүхдээ харуй бүрийд хүлээн зогсох эцэг, эхчүүд батална. Илүү цагаар ажиллах ▶



Гэрэл зургийг МРА/Б.Бямба-Очир

Эх сурвалж:
Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, биеийн тамирын заалны барилга хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал



“Төр болон хувийн хэвшлүүд нэгдсэн зорилгын төлөө сайн дурын үндсэн дээр харилцан зөвшилцөн хамтран ажиллах гэрээнд тулгуурлан боломж, хариуцлага, эрсэдлийг хамтдаа үүрэн ажиллах үйл явцыг төр хувийн хэвшлийн түншлэл гэнэ.”

Дэлхийн эдийн засгийн форум

▶ багш, сурган хүмүүжүүлэгчдээс гадна тоглох талбай, спорт заал, тухтай орчин үгүйлэх сурагчид ч ам уралдан “мөрөөдлийн жагсаалтаа” сонирхуулна. Халуунд халж, хүйтэнд хөрөн байж автобус дамжин сургуулийнхаа барааг харна гэдэг номын дуу сонсохоор яарах хүүхдүүдийн хувьд дэндүү халширмаар. Бөхчим ангид дөч, тавиулаа. Дараагийн анги ээлжээ хүлээн ангийн хаалганы “амар заяаг” нь үзүүлэхгүй. Энэ бол Монголын ирээдүй хойчийн боловсрол эзэмшиж буй сургалтын орчин.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2010 оны тооллогын дүнгээр хүн амын жилийн дундаж өсөлт 1.5 хувь болж, нийт хүн амд эзлэх сургуулийн насны хүн (0-19 нас) 37.7 хувь, түүний 34 хувийг 0-17 насныхан эзэлж байна гэсэн тоо

Эх сурвалж:
Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байр, биеийн тамирын заалны барилга хангамжийн талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал

3 ЕБС-ийн хүчин чадал

Үзүүлэлт	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
6-17 насны хүн ам	548.421	542.827	543.224	550.831	563.639
ЕБС-д хамрагдаж байгаа хүүхэд	505.409	510.568	521.263	539.028	562.270
Сургуулийн хүчин чадал /суудал/	406.940	427.309	449.824	474.845	502.813

гарчээ. Түүнчлэн боловсролын хөгжлийн шаардлагаар шинээр үүсч буй хэрэгцээ, одоо ашиглаж буй барилгын насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссан, зориулалтын бус барилгад сургалт явуулж байгаа зэрэг шалтгаанаас сургууль, цэцэрлэгийн суудал, орны хүчин чадал хүрэлцэхгүй хомсдох нь энгийн үзэгдэл болоод буй.

2015 онд гэхэд цэцэрлэгийн хамран сургалтыг 80 хувьд, суурь боловсролд

хамрагалдыг 100 хувьд, дотуур байранд хамрагдах хүсэлтэй хүүхдийг бүрэн хамруулах, бүх сургуулийг спорт заалтай болгох зорилтын хүрээнд нийт 196,3 мянган хүүхдийн хүчин чадалтай 686 сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилгыг шинээр барихад 829.5 тэрбум төгрөг шаардлагатай болно. Хүсэвч хөрөнгө нь хүрэлцэхгүй гэх төр үүнийг ганцаараа бүтээх боломжгүй. ▶

► Чадах ч үгүй. Иймд Засгийн газар боловсролын салбарын хөгжлөө төсвийн мөнгөөр аргацаах эсвэл тусламжийн санхүүжилт хүлээх бус нөөц бололцоогоо ашиглан хувийн хэвшилтэйгээ нягт хамтран ажиллахаас өөр таатай бас ашигтай хувилбар бага гэдгийг учир мэдэх салбарын хүмүүс хэлсэн юм.

Ирээдүйгээ баталгаажуулъя гэвэл XXI зууны боловсролын жишигтэй хөл нийлүүлэхээс өөр зам бидэнд үгүй. Гэвч бидэнд дадлага, туршлага руу гүн орсон эхлэл, хэрэгжилт гэх зүйл алга.

бүр байдаг. Зохицуулалт нь гэрээний заалтуудын дагуу явна” гэв.

Түүний хэлснээр боловсролын салбарыг чанаржуулах, хөгжүүлэхэд төр, хувийн хэвшил түншлэх зайлшгүй шаардлага байгаа аж. Төрийн гачлан хөрөнгө мөнгөний чадавх, арга барил, техник технологи дутмаг байгаад оршдог. Хүүхдэд ээлтэй сургуулийн орчин бүрдүүлэхэд зөвхөн мөнгө хангалтгүй. Хувийн хэвшлээс хүртэж болох шилдэг туршлага, дэвшилт технологи Монголынхоо үрсийг таатай, тухтай орчин үеийн сургуульд

хамтын ажиллагаанд бэлэн байна уу, боловсролын салбарт энэ түншлэлийг хэрхэн уяж өгөх үү гэдэг талаар бид саяхан сименар зохион байгуулж талуудын төлөөллүүдтэй уулзалт хийсэн. Одоо зөвлөмж боловсруулаад явж байна. Хууль зүйн орчныг сайн бүрдүүлэх шаардлагатай байгааг онцлох хэрэгтэй. Салбар бүрт нийцэх онцлогийг гаргахаар зорьж байна. Салбаруудын хувьд болоогүй байна. Тэглээ гээд зогсохгүй, урагшлахын төлөө алдаанаасаа суралцаад явах хэрэгтэй. Шилдэг туршлагыг

“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гол санаа нь хоёр тал өөрт буй давуу талуудаа нэгтгэн үр дүнд хүрэх”

Д.Байлхүү, Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх



Гэрэл зургийн МРА/Бямба-Очир

Дээсээ томх арга

Бага орлоготой улс оронд чиглэх тусламжийн санхүүжилт буурах төлөвтэй байгааг ЮНЕСКО-с гаргасан Education for all: EFA Global Monitoring Report 2013/14 тайланд дурдсан байна. Тэгэхээр төр, хувийн хэвшлийн түншлэлийг боловсролын салбарт чиглүүлэх хэрэгцээ, шаардлага улам чухал болох юм.

Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх Д.Байлхүү “Төр, хувийн хэвшлийн түншлэл бодлогоо тодорхойлсноор энэ ойлголт одоо л системтэйгээр хэрэгжих нөхцөл бүрдэж байна” гэсэн юм. Тэрбээр “Төр, хувийн хэвшлийн түншлэлд стандарт гэсэн тогтсон зарчим байдаггүй. Тухайн орон болон салбарын онцлогоос хамааран түншлэлийн хэрэгжилт янз

боловсрол эзэмших эрхээр хангах чухал түлхэц болох юм. Иймд төр, хувийн хэвшил хамтрах, нэгнээ дэмжин ажиллах шаардлага байгааг Д.Байлхүү ярьсан. Гэхдээ хууль эрх зүйн хүрээнд нийцсэн, үзэглэсэн гэрээний дагуу зөв хамтрах хэрэгтэй гэдгийг тэрбээр сануулсан юм.

Хувийн хэвшил төрийн үүрэгт ажлыг нугалаад ирэхээр төрийн оролцоо үгүй болно гэсэн үг биш. Төр хувийн хэвшлийг хэр хэмжээнд, ямар чиглэлд оролцуулах вэ гэдгийг сайтар тодорхойлох ёстой аж. “Төр, хувийн хэвшлийн түншлэлийг боловсролын салбарт хэрэгжүүлэх хөрс нь бэлэн бус байна. Тодорхой хэмжээнд арилжааны шинжтэй болсон тохиолдолд хувийнхан ашиг хүртэх боломж бүрдэнэ. Монгол Улс ийм төрлийн хоёр талт түншлэл,

нэвтрүүлэх, ингэхдээ улсынхаа нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай” хэмээн Азийн хөгжлийн банкны төслийн зөвлөх Д.Байлхүү онцолсон.

Аврах ажиллагаа

Боловсролын салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэл хэрэгжих боловсролын дэд бүтэц, дэмжих болон боловсрол олгох гэсэн үндсэн гурван чиг байдгийг Дэлхийн банк тэргүүтэй олон улсын байгууллагууд тодорхойлсон байдаг.

Боловсролын дэд бүтцээр барилга байгууламжийн асуудлыг авч үздэг бол дэмжих үйлчилгээ нь өдрийн хоол, спорт заал, лаборатори зэрэг хангамжийн асуудлыг хамруулдаг. Боловсрол олгох үйлчилгээнд тухайн ►

- ▶ сургуулийн менежмент, багш сурган хүмүүжүүлэгчдийн хангамж, сургалт, мэргэжил дээшлүүлэх гээд илүү өргөн хүрээнд сургуулийн үйл ажиллагааг зохицуулдаг байна.

Манай улсад боловсролын салбарт чиглэх хувийн хэвшлийн тусламжийн хүртээмж шинэ лабораторийн нээлт, нэрэмжит тэтгэлэг зэргээс хэтрэхгүй байгааг Боловсролын яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Б.Энхээ тайлбарласан юм. Тэрбээр “Төр, хувийн хэвшлийн түншлэл гэсэн малгайн дор боловсролын салбарыг дэмжиж буй хэлбэрүүд байна. Сургууль, цэцэрлэгүүдэд ашиглах тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлөх эсвэл хөнгөлттэй зээл олгох, байшин барилгаар хангах гэх мэт үйл ажиллагаа ч гэсэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэг хэлбэр. Дэмжих үйлчилгээний нэг хэлбэр хэрэгжиж байна гэсэн үг. Төр, хувийн хэвшлийн түншлэлд ойлголтын зөрүү байдаг. Хувийн хэвшлүүд боловсролын салбарт янз бүрийн хэлбэрээр хөрөнгө оруулж байгаа нь эргээд хүмүүн капиталдаа бэлтгэж буйн илрэл” гэв. Түүний хэлснээр хүн амын өсөлтийг улсын төсвөөр хангаж чадахгүй тул гаднаас хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх арга замыг сонгохоос өөр замгүй юм.

Тиймээс боловсролын дэд бүтцийг сайжруулах нь Монголд нэн тулгамдсан асуудал учраас төр хувийн хэвшлийн түншлэл энэ чиглэлд эхэлж, түрүүчийн сонгон шалгаруулалтыг хийгээд байгаа сайн мэдээ байна. Тодруулбал, Концессийн гэрээний хүрээнд 72 сургууль, цэцэрлэгийн барилга барих төсөл эхлэх шатандаа явж байгааг Эдийн засаг хөгжлийн яам гардаж буй аж.

Хувийн хэвшлийн зүгээс мэдээж энэ чиглэлд гаднын туршлагыг нэвтрүүлж, төр нь хамтран хийх ажлаа сайн ойлгох аваас жинхэнэ шинэ цагийн иргэдийн хүсдэг мөрөөдлийн сургуулийг барьж байгуулах ажил биелэлээ олох юм. Энэ талын сонирхол ч төрд болоод хувийн хэвшлийнхэнд ойрын ирээдүй мэт дуулдах аж. Энэ талаар сурвалжлан явах хүсэл байсан ч одоогоор бүх асуудал эхлэл төдий байгаа тул шаардлагатай мэдээлэл амар олдохооргүй байна. Арга ч үгүй. Сонгон шалгаруулалт ид явагдаж, шалгарсан нэг нь төртэй дараа дараагийн уулзалтын ширээнд сууж учир зүгээ ололцох тул үүнтэй холбоотой мэдээллийг манай сэтгүүл цаашид улам гүнзгийрүүлэн өгөх болно.

Ямартай ч төр, хувийн хэвшлийн түншлэлээр боловсролын салбарын дэд бүтцийг дэлхийн жишигт хүргэх эхлэл тавигдаж байгаа нь сайн хэрэг.

Ийнхүү дээс томж найзыгаа аврахаар олон бэршээлийг давж, олны хүчээр зорилгодоо хүрдэг бяцхан хулганы үлгэрийн адил шаварт унасан боловсролын салбараа татан гаргахын тулд төр, хувийн хэвшил хүчээ нэгтгэн, сайн ойлголцож ажиллаваас Монгол Улсын иргэн бүр XXI зууны дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэх боломж бүрдэх учиртай. Нөгөө талаас PPP олон салбарт хөгжил дэвшлийг авчирдаг. Тэгвэл төр, хувийн хэвшлийн түншлэл боловсролын салбарт бол мөрөөдөл бэлэглэгч юм. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Та сургууль, цэцэрлэгийн орчин нөхцөлийг ямар байгаасай гэж боддог вэ?

Биеийн тамирын талбайтай сургууль тун цөөн

Н.Лхавгасүрэн /Чингэлтэй дүүргийн иргэн/:

-Манай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын бааз суурь, суралцах орчин нөхцөл харахан сайн бэхжиж чадаагүй. Хэдий төрөөс боловсролын салбарт ихээхэн анхаарч байгаа ч бодит байдал дээр асуудал шийдэгдэхгүй үлддэг. Өөрөөр хэлбэл, төсөв мөнгөний хомсдолтой учраас бодитой хөрөнгө оруулалт тухайн сургуульд хийгдэхгүй байна. Энэ нь шат шатанд олгож буй төсвөө танадагтай холбоотой болов уу. Тухайн жилд орж ирсэн мөнгөөр нь ханандаа будаг түрхэж, шаландаа хулдаас авч дэвсээд л болчихож байна. Үүнээс илүү гарах хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай. Ингэснээр таатай орчин нөхцөл бүрдэх юм. Анги дүүргэлтийн хувьд улсын сургуулийнх хэт их. Энэ нь сурагчдын сурлагын амжилт, эрүүл ахуйд сөргөөр нөлөөлдөг байх. Дундаж болон түүнээс доогуур амьдралтай айлын хүүхдүүд л ийм орчин нөхцөлд суралцаж байна шүү дээ. Биеийн тамирын талбайтай сургууль Улаанбаатарт тун цөөн.

Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх нь зүй ёсны хэрэг

Т.Нэргүй /Чингэлтэй дүүргийн иргэн/:

-Ерөнхий боловсролын сургуулийн суралцах орчин нөхцөл сайжирч байгаа. Жил ахих тусам энэ чиглэлд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэж, шинээр сургууль, цэцэрлэг нэмэгдэж байна. Иргэн хүний хувьд одоогийн өөрчлөлт, шинэчлэлд сэтгэл хангалуун яваа. Мэдээж сайжруулах, улам шинэ шатанд гаргах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх нь зүй ёсны хэрэг. Манай хүүхдүүд 50 болон 23 дугаар сургуульд суралцдаг.

Бодит байдал хүнд байна

Д.Төмөрбаатар /Баянзүрх дүүргийн иргэн/:

-Зарим хувийн дунд сургууль болон цэцэрлэг олон улсын түвшинд нийцсэн таатай орчин бүрдүүлж байна. Гэхдээ хувийн сургуульд суралцаж байгаа хүүхдийн тоо маш бага. Дийлэнх хэсэг нь улсын сургуульд суралцдаг. Ингээд үзэхээр төвлөрөл хамгийн их байгаа тэр хэсэгт төрөөс анхаарч, тохь тухтай суралцах боломжит орчныг бүрдүүлж ▶

► өгөх хэрэгтэй. Бодит байдал хүнд байна. Үүнийг хүн бүр мэднэ. Улсын сургуулиуд бүгд тоглоомын болон биеийн тамирын хичээл ордог талбайтай байсан. Гэтэл өнөөдөр сургуулийн гаднах талбай нь хүртэл бусдын гарт орсон. Хамгийн наад зах нь сургуулийн цайны газар эрүүл ахуйн шаардлагыг хангаж байх учиртай.

Сургалтын орчны стандартыг даган мөрдөх хэрэгтэй

Б.Гэрэлцэцэг /Нийслэлийн 146-р цэцэрлэгийн эрхлэгч/:

-Жил бүр цэцэрлэгийн хүүхдийн тоо өсөн нэмэгдэж байна. Тиймээс олон бүлэг хичээллэх боломжтой цэцэрлэгийн барилга байгууламж шаардлагатай байгаа. Ингэснээр нэг багшид ногдох хүүхдийн тоо цөөрч, сургалтын чанарт ч ахиц гарна. Тохь тухтай орчин бий болно. Үүнээс гадна анги танхим, спортын болон урлагийн заал том байх асуудал гарч ирж байна. Түүнчлэн гэрэлтүүлэг, тавилга хэрэгсэл, угаалтуур, суултуур нь стандартын шаардлагад нийцсэн байх нь чухал. Өөрөөр хэлбэл, боловсролын салбар дахь сургалтын орчинд стандартыг дагаж мөрдөх хэрэгтэй.

Хүсэлт бодит ажил болж чадахгүй байна

Ч.Чанцал /Нийслэлийн 73-р дугаар сургуулийн захирал/:

-Улсын жишигт нийцсэн эрүүл аюулгүй орчин бүрдсэн сургуультай болох чиглэлээр цөөнгүй санал санаачилга сургуулийн зүгээс гардаг. Эцэг эхчүүдийн зүгээс ч мөн ялгаагүй богино хугацаанд сургалтын байртай болох асуудлыг тавьж ирсэн. Сурагчдад үйлчлэх автобустай, автомашины зогсоолтой байх хүсэлтийг ч иргэд байнга хэлдэг. Мөн өдөр өнжүүлэх бүлэг, сурагчдын бие бялдрыг хөгжүүлэх өрөө, спорт болон урлагийн тэнхим зэрэг нь сургуульд орчинд байвал зохих зүйлүүд. Хөрөнгө мөнгөний хомсдолоос үүдэн дээрх хүсэлт бодит ажил болж чадахгүй байгаа. ■

МЕНЕЖМЕНТ

ТҮНШЛЭЛИЙН ТУРШЛАГА

Б.ТУЯА

Ээлтэй орчинд боловсрол эзэмшинэ гэдэг хүний эрхийн үндсэн зарчмуудын нэг. Аж амьдралаа өөд нь татах түлхүүр үзүүлэлт. Үүнийг сайн мэдэх улс орнууд боловсролын салбараа олон жилийн турш “тойглож” ирсэн байдаг. Ингэхдээ төр нь хувийн хэвшилтэйгээ нягт хамтран ажиллаж шилдэг туршлагаараа үлгэрлэх болжээ.

Дээрх салбарт төр, хувийн хэвшил хамтрахдаа боловсролын дэд бүтэц, боловсролыг дэмжих үйлчилгээ үзүүлэх чиглэлд түлхүү анхаардаг аж. Учир нь сургууль бол хүүхдийн хоёр дахь гэр. Амьдралынхаа багагүй хугацааг өнгөрүүлэх тэрхүү орчин нь эрүүл, цэвэрхэн, найдвартай бас хүүхдийн эрхийг дээдэлсэн байх учиртай. Тэгвэл энэ зарчмаар олон улсын хэмжээнд

шилдэг туршлагыг нэвтрүүлсэн орнууд цөөнгүй байдаг.

Боловсролын салбарын дэд бүтцийн асуудалд сургууль, цэцэрлэгийн барилга барих, ашиглах, эзэмших тухай голчлон хамааруулахын зэрэгцээ барилгын хангамжид чиглэсэн асуудлыг тусгадаг ажээ. Ихэнх тохиолдолд хувийн хэвшил барих, эзэмших болон дэд бүтцийн бусад асуудлыг хариуцах бөгөөд төр тэдгээрийг урт хугацааны гэрээний дагуу төлбөртэйгөөр ашигладаг. Харин гэрээт хугацаа дуусмагц хувийн хэвшил эзэмших эрхийг төрд хүлээлгэн өгдөг байна. Тухайлбал, “Building schools for the future in UK” хэмээх Их Британид хэрэгжүүлж буй төсөл боловсролын салбарын дэд бүтцийн бүтээн байгуулалтын сонгодог жишээ болдог. Энэ хүрээнд хувийн хэвшил сургууль барихаас ►



Боловсролыг дотоод эх үүсвэрээс санхүүжүүлэх боломжтой орнууд

Татвар, ДНБ-ий харьцаа	Улсын нэр	2011		2015		2015 /нэгж үнэ/			
		ДНБ-д эзлэх хувь	ЗГ-ын нийт зарлагад эзлэх хувь	Татвар ДНБ-д эзлэх хувь	ДНБ-д эзлэх хувь	Татвар ДНБ-д эзлэх хувь	Нийт нэмэлт санхүүжилт /2015/	Бага ангийн сурагчид ногдох тогтмол зардал	Бага ангийн сурагчид ногдох зардал /татвар оруулсан/
		%	%	%	%	%	US\$ millions	US\$	US\$
Татвар, ДНБ-ий харьцаа 10 хувиас бага	Бангладеш	2.2	14.1	8.6	4.2	13.6	3198	101	216
	Бутан	4.7	11.5	9.9	7.9	14.9	94	255	924
	Мьянмар	0.8	18.1	3.9	2.3	8.9	1 000	389	513
	Камбож	2.6	12.1	10.4	4.9	14.4	438	82	232
Татвар, ДНБ-ий харьцаа 10-12.5 хувь	Индонез	3.0	15.2	10.9	4.7	14.9	19 506	526	1 049
	Пакистан	2.4	9.9	10.2	5.2	14.2	7 241	62	262
Татвар, ДНБ-ий харьцаа 12.5-15 хувь	Балба	4.7	20.2	13.1	5.3	16.1	144	160	185
	Филиппин	2.7	15.0	13.2	4.2	16.2	5 361	442	679
	Шри-Ланка	2.0	12.9	13.3	3.9	16.3	1 509	292	970
Татвар, ДНБ-ий харьцаа 15-20 хувь	Энэтхэг	3.3	10.5	15.9	6.4	17.9	70 529	157	558
	Киргизстан	5.8	18.6	19.5	6.7	21.5	76	662	751
	Мозамбик	6.4	17.0	17.7	7.9	19.7	274	103	137
Татвар, ДНБ-ий харьцаа 20 хувиас их	Монгол	5.5	11.9	28.0	8.9	29.8	539	953	2 391
	Узбекистан	6.4	20.5	24.0	6.8	25.8	234	1 170	1 228
	Вьетнам	6.6	19.8	23.5	7.0	25.3	750	446	732

Эх сурвалж: UNESCO 'Education for All Global Monitoring Report 2013-14'

гадна үйл ажиллагаанд санхүүжилт хийх бөгөөд байгууламжийг сургуулийн зориулалтаар 30 хүртэлх жил ашиглах эрхтэй байх аж. Ашиглагч тал гэрээнд заасан хугацаанд төлбөрийг бүрэн барагдуулах үүрэг хүлээдэг.

Дэд бүтцэд хамаарах бас нэгэн шалгуур бол эрүүл ахуйн шаардлага хангасан анги танхим, сургалтын болон хүрээлэн буй орчин. Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлснээр сурагчийн бүтээмж, чадамж дээшилдэг болохыг олон улсын судалгааны нэг бүс



байгууллага баталжээ. Мөн Бельгийн Антверпены Их сургуулийн явуулсан “Дэд бүтэц сургалтад нөлөөлөх нь” судалгаанд 14-15 насны 2032 сурагчийг хамруулжээ. Улмаар орчин бас хангамж сайн байх нь сурагчдын сурах явцад шууд нөлөөлдөг болохыг баталсан байна. Харин дэд бүтэц хангалтгүй, муу орчинд хүмүүжиж буй сурагчдын дийлэнх нь номын сан, зориулалтын анги танхим, тоног төхөөрөмж, хооллох бүс мөн ногоон байгууламж чухал байгааг учирлажээ. Дани, Нидерланд зэрэг боловсролын салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийг тэргүүлэх хэмжээнд хүргэж чадсан орнуудын хувьд сургалтын чанарыг дэд бүтэц, хангамжтай уяж өгснөөр төрийн болон хувийн сургуулиудын дунд өрсөлдөөн бий болгох, улмаар сургалтын чанарыг аль ч түвшинд сайжруулна гэсэн зорилгодоо хүрч чадсан юм.

Боловсролыг дэмжих үйлчилгээ нэвтрүүлэх нь хувийн хэвшил төрийн ажилд дэм болж буйн тод илрэл билээ. Ингэхдээ хувийн хэвшил сургуулиудад шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх, анги танхим, спорт заалны тохижилтын ажлыг гүйцэтгэх, өдрийн хоолоор хангах гээд өргөн хүрээг хамарч болох туслалцаа үзүүлэх юм.

Эрүүл биед саруул ухаан оршдог. Хөгжингүй орнуудын хувьд залуу үеэ эрүүл, чийрэг байлгах асуудалд голлон

анхааран ажилладаг. Харин хөгжиж буй эсвэл буурай орнуудын хувьд энэ сэдэв орхигдох нь бий. Боловсролын тогтолцоо өндөр хөгжсөн Англи улсад ЕБС-ийн сурагчдыг амин дэмээр баялаг хоол хүнсээр хангах нь сурлагын түвшинд эерэгээр нөлөөлнө гэж үздэг байна. Иймд хүнсний аюулгүй байдал, хадгалалт, тээврийн стандартад нийцсэн өдрийн хоолоор сурагчидаа хангах асуудлыг чухалчлан авч үздэг.

Мөн дэлхий нийтийн цахим хөгжилтэй хөл нийлүүлэх боломжоор хангах асуудал өнөө цагт түншилж болох чухал чиглэлүүдийн нэг болоод буй. Энэ тал дээр Энэтхэг улс мэдээлэл технологи нэвтрүүлэх туршлагаараа тэргүүлдэг. Мэдээлэл технологийн салбарт хүчээ сорих Энэтхэгийн хувийн хэвшлийнхэн улсынхаа сургуулиудыг шинэлэг програм хангамжаар “тоноглож” багш, сурагч хоорондын харилцааны зарим хэлбэрийг (хичээл заах, даалгавар солилцох арга барил гэх мэт) хөнгөвчлөхийн хажуугаар сургуулийн удирдлагын түвшинд шаардлагатай шинэ технологийг менежменттэй холбон хэрэгжүүлдэг аж. Ингэхдээ төр хувийн хэвшилтэй ихэнх тохиолдолд 3-5 жилийн гэрээ байгуулах бөгөөд гэрээний хугацаа дуусахад төр гэрээний дагуу төлбөр тооцоогоо барагдуулдаг юм байна. ■

НОГООН БАРИЛГА

ХОЙЧ ҮЕДЭЭ ЗОРИУЛАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Х.ХУЛАН

Хүн төрөлхтөн бид ганцхан цэнхэр гаригтай. Эх дэлхий хэмээх гариг маань 4.6 тэрбум гаруй жил оршин тогтносоор ирсэн билээ. Гэтэл өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний экологийн ул мөрийг тооцвоос 2030 он гэхэд дэлхийн нөөц боломжоос хоёр дахин давахаар байгаа аж. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, хүн амын хурдацтай өсөлт, байгалийн нөөцийн хомсдол нь тогтвортой хөгжлийн замналыг сонгох хэрэгтэйг харуулж байна. Үүний тулд байгальд ээлтэй, “ногоон” гэгдэх загварыг хүн бүр аж амьдрал, бизнестээ хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Ногоон барилга

Тогтвортой хөгжил гэдэг нь өнөөгийн хүн амын хэрэгцээг хангаад зогсохгүй хойч үеэ мөн хамт бодолцохыг хэлнэ. Түүнчлэн энэ нь экологийн, нийгмийн болон эдийн засгийн гэсэн үндсэн гурван тулгуур хэсгээс бүрддэг. Ийнхүү “ногоон” хэв маягт орох алхмуудын нэг бол ногоон барилга, байгууламжийг дэмжих явдал мөн.

Дэлхийн олон улс оронд байгаль орчин болон хүний эрүүл мэндэд халгүй барилга байгууламжийг эрчимтэй хөгжүүлэх болжээ. Эл ногоон барилга нь хүний эрүүл мэнд, тав тухыг хангахаас гадна байгалийн нөөцийг ариг гамтай зарцуулахад хувь нэмрээ оруулдаг онцлогтой. Цаашилбал, барилгын компаниудын нийгмийн хариуцлага ч гэсэн сайжирна.

Тэгвэл ногоон барилга гэж чухам юуг хэлэх вэ? Энэ талаар Монголын үндэсний их сургуулийн Инноваци, эрдэм шинжилгээний асуудал

эрхэлсэн дэд захирал Д.Нэргүйгээс тодруулахад: “Ногоон барилгын үзэл баримтлалын тухай ойлголт анхлан гарч ирсэн 1960-аад оны үеэс эхлэн энэ талаар тодорхойлолт олон ч баримталдаг нэг гол зарчим байдаг. Энэ нь барилга барихад ашиглаж буй бүхий л материал, дулаан, эрчим хүч, усыг хэмнэлттэй ашиглах, агаар, хөрс, усыг бохирдуулахгүй байх, тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлах, эрүүл мэндийн стандартыг мөрдөх зэргийг өөртөө агуулсан байдаг. Ногоон барилга гэдэг нь зөвхөн тухайн нэгэн барилгын асуудал бус, барилгын орчин тойрон, олон нийтийн хяналт,

төлөвлөх, зураг төсөл зохиохоос эхлээд барилга, байгууламжийн ашиглалтанд байх бүхий л хугацаанд хамаатай ойлголт. Ногоон барилгын зарчимд нийцсэн барилга гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд ээлтэй байх юм” гэж хэллээ. Түүгээр ч зогсохгүй барилга барьж байх үедээ тоос босгохгүй, орчин тойрондоо аль болох сөрөг нөлөө үзүүлэхгүй байдаг гэнэ.

Ногоон сургууль ба Английн туршлага

Бали арлын нэгэн сургуулийг хулсаар



Гаднаа тоглоомын талбай бүхий ногоон цэцэрлэг, ХБНГУ

газар ашиглалт, бүхий л төрлийн байгалийн баялгийг үр ашигтай ашиглах, хэмнэлттэй зарцуулах зэрэг асуудлыг хамарсан ойлголт гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, ногоон барилга нь тухайн барилга байгууламжийг

хийжээ. Тиймээ, энэ бол ногоон сургууль мөн. Гэхдээ байгаль орчинд ээлтэй байхын тулд сургуулийг заавал ой мод, ширэнгэд барина гэж байхгүй. Ногоон сургууль нь жирийн сургуультай харьцуулахад ▶



Гэрэл зургийг Х.Хулан

ХБНГУ-ын Ихенхаузен хот дахь цэцэрлэг

Монголын Үндэсний их Сургуулийн Инноваци, эрдэм шинжилгээний асуудал эрхэлсэн дэд захирал, Монголын ногоон барилгын хүрээлэнгийн ТУЗ-ийн гишүүн Д.Нэргүй:

Ялангуяа цэцэрлэг, сургуулийн барилгад маш их анхаарах хэрэгтэй. Өнөөдөр бид ихэнхдээ хүний эрүүл мэндэд хортой, хурц үнэртэй будаг, цавуу зэргийг хэрэглэж байна. Энэ нь хүүхдүүдийн эрүүл мэндэд хортой. Цэцэрлэг, сургуулийн орчин бохирдол ихтэй. Тоос шороо ихтэй, ногоон байгууламжгүй.

Жил бүр цөөнгүй сургууль, цэцэрлэгийг төсвийн хөрөнгөөр барьж ашиглалтанд оруулдаг. Иймд нэг талаас саяхан УИХ-аар батлагдсан Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд, нөгөө талаас бидний ирээдүй болсон хүүхдүүдийн эрүүл мэндийг багаас нь анхаарах зорилгоор, ногоон барилгын зарчимд нийцсэн цэцэрлэг, сургуулийн барилга барих шаардлага тавих бүрэн боломжтой.

▶ хог хаягдлаа аль болох ихээхэн хэмжээгээр бууруулж, сэргээгдэх эрчим хүч хэрэглэдэг. Үүний тулд тэд эрчим хүчний хэмнэлттэй чийдэнгийн шил ашиглаж, усны хэрэглээгээ багасгаж, дээвэр дээрээ нарны панель суурилуулна. Товчоор хэлэхэд, ногоон сургуулийг заавал хөдөө орон нутагт төдийгүй хотод ч гэсэн барьж байгуулдаг.

Английн зохион бүтээгч Давид Ллойд Жонес ба түүний баг улсынхаа Засгийн газраас зарласан сургуулийн барилгыг шинэчлэн, тогтвортой болгох 90 тэрбум паундын төслийг гүйцэтгэгчээр шалгарсан. Тэрбээр ажлаа эхлүүлхээс өмнө сургууль болон дүүргийн иргэдтэй уулздаг гэнэ. Түүний асуудаг асуулт: “Та нар ямар сургуультай болохыг хүсдэг вэ?” Энэхүү асуултыг томчуудаад төдийгүй сурагчдад зааваал тавьдаг аж. Тухайлбал, нэгэн дунд сургуулийн сурагчдын одон орон судлалын булантай болох хүсэлтийнх нь дагуу ангийнх нь загварыг гаргаж өгсөн байна.

Түүнийхээр бол, тогтвортой барилгын загварыг гаргахын тулд тухайн газрынхаа цаг уур, тогтвортой технологи болон орон нутгийн зах дээрх материалыг судлуштай гэж үздэг. Мөн шинэ, хуучин технологийг хамт ашигладаг туршлагатай. Жишээ нь, шилэн хана нарны элчийг сайн нэвтрүүлж гэрэл гэгээ сайтай байдаг ч зарим хэсэгт нь хөшиг татаж тусгаарлах ханын үүргийг гүйцэтгүүлэх боломжтой байдаг. Түүнчлэн, тухайн орон нутгийн цаг агаарын нөхцөлийг сайтар судлах нь сургуулийн барилгын загварыг үр өгөөжтэй болоход нөлөөлнө гэсэн зарчмыг баримталдаг байна.

Ногоон барилга ашигтай юу?

Хүний буруу үйл ажиллагаанаас болж дэлхийн эко тогтолцооны тэнцвэр улам бүр алдагдсаар л. Энэ нь байгаль болон бидний хүрээлэн

буй орчинд нөхөж болзошгүй хохирлыг авчрах аюултай. Барилга байгууламж нь дэлхийн нөөц ашиглалт, бохирдолтод хамгийн их нөлөөтэй гэж мэргэжилтнүүд үздэг. Тэгвэл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудад байшин, барилга нь эрчим хүч ашиглалтын 25-40 хувь, түүхий эдийн 30, дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын 30-40, мөн хог хаягдлын 40 хувьд шууд хамааралтай байдаг аж. Түүнчлэн эдгээр орны оршин суугчид амьдралынхаа 90 шахам хувийг байшин дотор өнгөрөөдөг гэсэн тооцоог Францын эрдэмтэд гаргажээ. Иймд тэдний эрүүл мэнд ч гэсэн амьдарч буй орчинтой салшгүй холбоотой байдаг гэнэ. Барилгын салбар эрчимтэй хөгжих ирээдүйтэй манай оронд саяхнаас эхэлж байгаль орчинд ээлтэй ногоон барилгыг барих ажил өрнөж байна. Ногоон барилга нь хойч үедээ зориулах томоохон хөрөнгө оруулалт маргаангүй мөн юм. ■



Гэрэл зургийн МРАБямба-Очир

АЙЛЧЛАЛ

ӨНДӨР БОСГЫГ ДАВАХЫН ТУЛД

С.ЗАЯА

ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад хагас өдрийн ажлын айлчлал хийгээд буцсан ч хоёр орны хамтын ажиллагааг сайжруулах цөөнгүй баримт бичигт гарын үсэг зурлаа. Түүний айлчлалыг олон улсын шинжээч, ажиглагчид янз бүрээр дүгнэн бичиж байсан. Эдийн засаг нь сайнгүй байгаа Монголын хувьд хойд хөршийнх нь төрийн Тэргүүн айлчилсан нь чухал алхам болж байна гэж дүгнэж ч байв.

Хоёр тал айлчлалын хүрээнд 14 санамч бичигт гарын үсэг зурсныг бид цахим хуудсаараа дамжуулан тухайн үед нь мэдээлж байсан.

Хоорондын яриа хэлцэл, тохироогоо манай тал хэр сайн биелүүлэхээс их зүйл шалтгаалахаар байна. Хоёр орны худалдааны тэнцвэрт харьцаа хэт зөрүүтэй байгаа. Өөрөөр хэлбэл, хоёр улсын худалдааны эргэлт 2013 онд 1623.6 сая ам.долларт хүрчээ. Ингэхдээ Монголын импорт 1561.9 сая, экспорт 61.8 сая ам.доллар болсон нь манай талын худалдааны алдагдал 1.5 тэрбум ам.доллартай тэнцэхэд нөлөөлсөн аж. Худалдааны алдагдлын хэмжээ ийн өндөр гарсан нь нефтийн бүтээгдэхүүнийхээ 90 орчим хувийг Оросоос импортолдогтой холбоотой байгаа юм.

Манай улс одоогоор Орос руу савхи,

илгэн хувцас, үслэг эдлэл бага хэмжээний мах болон жонш, лейцит, нефелин ба нефелинт сиенит гаргаж байна. Харин ОХУ-аас нефтийн бүтээгдэхүүн болон бусад нэр төрлийн бүтээгдэхүүн импортоор авч буй.

Экспорт бага байгаа шалтгаан нь тус улсын гаалийн татвар өндөр байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, үслэг эдлэл, хивс тус бүр 22.5 хувийн татвар төлдөг аж. Үүн дээр нэмүү өртгийн тав, худалдааны мөн хэмжээний хувийн татвар нэмэгддэг. Худалдаанаас алдагдал хүлээхгүйн тулд одоо гарч буй боломжоо ашиглах ёстойг судлаачид хэлж байна. Айлчлалын үеэр Монголд үйлдвэрлэсэн ▶

▸ барааг ОХУ-ын зах зээлд 20 жилийн хугацаатай татвар, гаалийн хураамжгүйгээр, хэмжээ харгалзахгүй нийлүүлж байх гэрээ хэлэлцээрийг ойрын үед эхлүүлэх саналтай байгаагаа Монголын тал илэрхийлсэн. Энэ асуудал нааштайгаар шийдэгдэж болох юм. Гэхдээ манай тал гаргасан шийдвэртээ эргэж буцахгүйгээр тууштай байвал шүү дээ.

В.В.Путин ба Монголын эдийн засаг

В.В.Путины айлчлал Монголын эдийн засагт ямар үр дүн өгөх вэ. Хятадын даргын айлчлалын өмнөх өдрүүдээс буурч байсан ам.долларын ханш хойд хөршийн төрийн Тэргүүний айлчлалын дараачаас дахин өсч эхлэв. Ямартай ч айлчлалын хүрээнд Монгол-Оросын Хөгжлийн банкууд “Үүргийн бичиг” байгуулсан. Банкууд хоорондоо ахисан

4”-ийн өргөтгөлд зориулан 74 орчим сая ам.долларыг ОХУ-ын Хөгжлийн банкнаас зах зээлийн боломжийн хүүтэйгээр санхүүжүүлэхээр боллоо. Улсын төсвийн дэмжлэггүйгээр, Монгол Улсын Хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжих “ТЭЦ 4”-ийн өргөтгөлийн төсөл нь нийт өртгөө өөрөө нөхөх онцлогтой. “Үүргийн бичиг” нь анхан шатны хэлэлцээний дүнд байгуулсан баримт бөгөөд зээлийн гэрээний судалгааг одоо хийж буй юм. Цаашлаад зээлийн гэрээ эцэслэн бэлэн болох хүртэл тодорхой мэдээлэл өгч байх аж.

Монгол, Оросын стратегийн түншлэлийн гол гол чиглэлийг айлчлалын үеэр талууд хэлэлцсэн. Ингэхдээ худалдаа, эдийн засгийн салбараа хөгжүүлэх төлөвлөгөөг тодорхойлжээ. Энэ нь шинэ үйлдвэрлэлийг бий болгох, хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтыг

20-иод мянган тонн мах экспортолж байж. Тиймээс манайх хойд хөршид экспортолж бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлээр идэвх санаачилгатай, үр дүнтэй ажиллахаа хэлсэн.

Харин В.В.Путин “Монгол Улс манай мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд Оросын зах зээлд их хэмжээний мал аж ахуйн болон мах, махан бүтээгдэхүүн гаргах боломжтой. Хоёр орны мэргэжилтнүүд энэ тал дээр ажиллаж байгаа. Нааштай үр дүнд хүрнэ гэдэгт найдаж байна” гэсэн.

Оросуудын мах махан бүтээгдэхүүн дээр тавьдаг шаардлага өндөр. Наад захын жишээ дурьдахад, сүүлийн гурван жил мал, амьтны гоц халдварт өвчин Монголд гараагүй байх ёстой гэж шаарддаг. Харамсалтай нь, энэ шаардлагыг манайх сүүлийн жилүүдэд хангаж чадаагүй учраас хоёр орны уламжлал болсон махны худалдаа өдгөө зогсонги байдалд хүрээд байгаа юм. Мөн манайх мах бэлтгэлийнхээ 90 хувийг үйлдвэрлэлийн бус аргаар хийдэг.

Гэтэл бид социализмын үед хойд хөршид махаа хэдэн зуун мянган тонноор нь экспортолж байсан түүхтэй. Монголд “махны” хэмээн нэрлэгддэг доктор С.Дэлэг энэ талаар “Манайхан ариун цэвэр, эрүүл ахуй гэхээр шүлхий, боом ярьдаг. Гэтэл төр засгаас энэ өвчний эсрэг багагүй ажил хийж байна. Харин үйлдвэрлэлийн шатанд сойлтын технологио сайн мөрдөж, малыг зөв үе шаттай төхөөрдөг уламжлалаа сэргээх хэрэгтэй. Том зүйл ярихаасаа өмнө Монгол хүн хийж чаддаг байсан зүйлээ мэддэг, чаддаг болох ёстой. Тэгж байж махны чанар ариун цэвэр, эрүүл ахуй сайжирна” гэв.

Гэхдээ Оросууд манайхаас мах авахаар болов. Тус улсын үйлдвэрлэлийн эрүүл ахуй, технологийн мэргэжилтнүүд Монголын нядалгаа, боловсруулах үйлдвэрийг шалгаад дуусчээ. ҮХАА-н сайд Ш.Түвдэндорж ОХУ руу зорьж энэ талаар яриа хэлэлцээр хийхээр болж.

Түүнчлэн “Махаа нэмүү өртөг шингээн гаргах хэрэгтэй. Одоо манай гаргаж ▶

Экспорт бага байгаа шалтгаан нь тус улсын гаалийн татвар өндөр байдагтай холбоотой. Өөрөөр хэлбэл, үслэг эдлэл, хивс тус бүр 22.5 хувийн татвар төлдөг аж. Үүн дээр нэмүү өртгийн тав, худалдааны мөн хэмжээний хувийн татвар нэмэгддэг.

түвшинд хамтран ажиллах, хоёр орны худалдааны төслүүдийг санхүүжүүлэх, тодорхой бараа бүтээгдэхүүний чиглэлээр худалдаа явуулахдаа хоёр талын үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийхийг анхны байдлаар тохиролцсон юм.

Харилцан худалдаа эрхлэхдээ хоёр улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг ашигласнаар гарах олон эерэг үр дүнгийн нэг нь манай улсаас ОХУ руу экспортолж бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ нэмэгдэх давуу тал бий болно гэж Хөгжлийн банкныхан үзэж байна. Энэ тохиролцоо ажил хэрэг болон хэрэгжвэл ам.долларын ханш тогтворжих боломж бий. Мөн “ТЭЦ

урамшуулах, хүмүүнлэгийн хэлхээ холбоог өргөтгөхөд чиглэх аж.

Махны экспорт нэмэгдэнэ

50 саяар тоологдох малтай монголчууд махаа экспортод гаргах сонирхолтой байгаа. Үүнд Оросын талаас тавьдаг хорио цээр чөдөр тушаа болдог. Гэхдээ Оросууд Монгол малын махны чанарыг сайн мэдэх хүмүүс. Манай хоёр орон энэ чиглэлээр эртний уламжлалт харилцаатай явж ирсэн ч Монгол малын мах өнөөг хүртэл Оросуудын өндөр босгыг давж чадсангүй. Сүүлийн 4-5 жилийг эс тооцвол манайх хойд хөршид жилд

- буй бага хэмжээний мах нь хөлдөөсөн гулууз хэлбэртэй байгаа” хэмээн ХААИС-ийн багш Л.Бадамханд хэлсэн.

Хоёр улсын худалдааны нөхцөлийг нэн тааламжтай болгож 2020 он гэхэд худалдааны эргэлтийг 10 тэрбум ам.долларт хүргэхээр хоёр улсын Ерөнхийлөгч ярилцсан. Тэгэхээр бидэнд тушаа болдог дээрх асуудлуудаа нэг мөр шийдэх шаардлага бий боллоо. Ингэж байж 1.6 тэрбум ам.долларт тэнцэж байгаа худалдааны эргэлтийг 2020 онд 10 тэрбумд хүргэнэ. Цаасан дээр бус амьдрал дээр хэрэгжүүлэхийн тулд тогтвортой бодлого, зөв менежмент хийх ёстой болж байна.

Дараах баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа

1. Иргэд харилцан зорчих нөхцөлийн тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
2. Хууль бусаар оршин сууж байгаа иргэдийг буцаан шилжүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
3. Ойг гал түймрээс хамгаалах тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр
4. Иргэний нисэхийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Зам, тээврийн яам, ОХУ-ын Тээврийн яам хоорондын санамж бичиг
5. Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай Монгол Улсын Зам тээврийн яам, ОХУ-ын “Оросын төмөр зам” НХ нийгэмлэг хоорондын хэлэлцээр
6. Хамтран ажиллах тухай хоёр улсын Хууль зүйн яам хоорондын хэлэлцээр
7. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам, ОХУ-ын Барилга, орон сууц-нийтийн аж ахуйн яам хоорондын санамж бичиг
8. Монгол-Оросын эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд хамтран ажиллах тухай хоёр улсын Эдийн засгийн хөгжлийн яам хоорондын санамж бичиг
9. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, “Газрын тосны Роснефть” НХ нийгэмлэг хоорондын хэлэлцээр
10. Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн үйлчлэлийг сунгах тухай протокол
11. Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Сангийн яам, ОХУ-ын Холбооны төрийн сан хоорондын санамж бичиг
12. Монгол Улсын Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар, ОХУ-ын Холбооны шилжилт хөдөлгөөний алба хоорондын санамж бичиг
13. Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз, ОХУ-ын “Россия сегодня” Олон улсын мэдээллийн агентлаг хоорондын санамж бичиг
14. Хамтран ажиллах тухай “МИАТ” ХК болон “Аэрофлот” компани хоорондын санамж бичиг зэрэгт гарын үсэг зурлаа.

Уул уурхай, зам тээвэрт яаж хамтрах вэ

Монгол Улсын тээврийн дэд бүтцийг хөгжүүлэхэд талууд хамтын ажиллагаагаа идэвхжүүлэхээр боллоо. Төмөр замын сүлжээг өргөтгөснөөр баялаг ихтэй ч хүрэхэд бэрхшээлтэй уул уурхайн орд газруудыг ашиглах тээврийн хүчин чадлыг нэмэх ач холбогдолтой гэнэ. Хоёр улсын хамтарсан хөрөнгө оруулалттай уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет” компани Монгол Улсын ДНБ-ий 20 хүртэлх хувийг хангаж байгаа юм. Тэдгээрийн технологийн иж бүрэн шинэчлэлийг хийхээр төлөвлөж буй аж.

Мөн айлчлалын үеэр хөндөгдсөн нэг чухал асуудал нь Оросын “Роснефть” компани Монголын зах зээлд оролцоогоо өргөжүүлэх төлөвлөгөөтэй буй аж. Тус компани Монгол Улсын нефтийн бүтээгдэхүүний хэрэгцээний ихэнх хувийг нийлүүлж, “Чингис” хаан олон улсын нисэх онгоцны буудлыг шатахуунаар хангаж байгаа юм. Үүнээс гадна “Роснефть” манай улсын иргэдийг өөрсдийнхөө зардлаар ОХУ-ын их, дээд сургуульд суралцуулахаар болжээ. Ингэхдээ газрын тос, инженер зэрэг нарийн мэргэжлээр сургахаар болжээ. Тэд өмнө нь Засгийн газарт 100 шатахуун түгээх станц барих санал тавьж байсан ч УИХ-аас дэмжлэг авч чадалгүй, замхарч байсан юм.

Зам, тээврийн салбарын тухайд УБТЗ-ыг шинэчлэх, хөгжүүлэх стратегийн түншлэлийн гэрээнд гарын үсэг зурлаа. УБТЗ-ыг шинэчлэх, хөгжүүлэх хүрээнд УБТЗ-ын гол шугамыг хос, цахилгаанжсан болгох, тээх нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал ийн шийдвэрлэгдэж байна. Тодруулбал, УБТЗ-ыг Эрдэнэтээс Завханы Арц суурийн боомт хүргэх аж. Ингэснээр Монгол Улс ОХУ руу шинэ төмөр замын гарцтай болох юм. Мөн Монгол Улс баруун хилээрээ ОХУ-тай холбогдсон төмөр замын шинэ коридор байгуулах судалгаа, ТЭЗҮ-ийг Оросын талтай хамтран хийх аж. БНСУ-ын Ражин боомтыг ОХУ-тай хамтран эзэмшихээр талууд тохиролцоонд хүрчээ. Ингэснээр манай улс анх удаа өөрийн гэсэн далайн боомттой болж байгаа юм.

В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалаар дэд бүтэц, дамжин өнгөрөх тээвэр, худалдаа эдийн засгийн, санхүү хөрөнгө оруулалтын асуудлаар тохиролцоонд хүрч чадлаа. Мөн хүмүүнлэгийн салбарт болон олон улс, бүс нутаг, гурван талт харилцааны зэрэг өргөн хүрээний асуудлаар санал солилцож тодорхой үр дүнд хүрэв. ■

ДЭЛХИЙН БАНК

Н.ЭНХБАЯР: УНАЛТЫГ СААРУУЛЖ БУЙ САЛБАРЫГ БОДЛОГООР ДЭМЖИХ ЁСТОЙ

Д.БЭХБАЯР

Н.Энхбаяр. Тэрбээр 1992 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг эдийн засагч мэргэжлээр төгссөн цагаас Сангийн яаманд 16 жил тасралтгүй ажиллажээ. Тус яамны Төсвийн бодлогын газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, газрын орлогч дарга, Макро эдийн засгийн газрын даргаар ажиллахын зэрэгцээ Олон улсын валютын сангийн тэтгэлгээр Японд Засгийн газрын нийтийн санхүүгийн бодлогын чиглэлээр суралцсан байна. 2008 оноос Ерөнхий сайд асан Сү.Батболдын зөвлөхөөр гурван жил ажиллаад 2011 онд Дэлхийн банкны төв оффист иржээ. Сэтгүүлч миний бие өнгөрсөн долдугаар сард АНУ-ын Вашингтон хотноо ажлаар очих үедээ Н.Энхбаяр зөвлөхтэй уулзаж ярилцсан юм. Дэлхийн банкны төв оффист өрнөсөн ярилцлагаа уншигч танаа хүргэж байна.

-Та Дэлхийн банкны төв оффист ямар алба хашиж байна вэ?

-Дэлхийн банкны Гүйцэтгэх захирлын зөвлөхөөр ажилладаг. Дэлхийн банкны бүрэлдэхүүнд Олон улсын хөгжлийн агентлаг, Олон улсын хөрөнгө оруулалт, хөгжлийн банк, Олон улсын санхүүгийн корпораци, Олон талын батлан даалтын байгууллагууд (IDA, IBRD, IFC, MIGA) байдаг. Тус банкны гишүүн 180 гаруй орныг төлөөлсөн 25 захиралаас Гүйцэтгэх захирлуудын зөвлөл бүрддэг. Дэлхийн банкны, нөгөө нь Олон улсын санхүүгийн корпорацийн гэсэн хоёр төрлийн Зөвлөлийн хурал болдог. Эдгээр захирлын зөвлөл долоо хоног бүрийн гурван өдөр байнга хуралдаж, улс орнуудад хэрэгжүүлж буй хөгжлийн бодлого хөтөлбөр, Дэлхийн банкны баримталдаг стратегийг хэлэлцэж баталдаг. Монгол улсын хувьд 23 дахь жилдээ гишүүний үүргээ гүйцэтгээд явж байна. Энэ жил Дэлхийн банк анхлан үүсэн байгуулагдсаны 70 жилийн ой тохиож байгаа юм. Энэ хугацаанд ядуу буурай олон улс орнуудыг хөгжлийн шинэ шатанд гаргахад туслалцаа үзүүлсэн байна. ▶



Н.Энхбаяр: Зөвлөх бол алив асуудалд санал дүгнэлт өгөх хэмжээний олон талын туршлагатай байх ёстой

► Хөрөнгө мөнгөнөөс гадна бодлогын туслалцаа өөрөөр хэлбэл, хөгжлийн зөв арга зам, бусад орны туршлага, мэдлэг солилцуулахад түлхүү анхаарч ирсэн гэж ойлгож болно.

Австрали, Өмнөд Солонгос, Шинэ Зеланд, Камбож болон Номхон далайн арлуудын 14 улсын төлөөлөл нийлж, нэг бүлэг газар болж ажилладаг. Энэ бүлэгт Монгол Улс багтаж байгаа. Газар зүйн байршлын хувьд алс хол байгаа ч хөгжлийн олон талын төстэй байдлаараа хуваагдсан байдаг. Энэ бүлэгт хөгжлийн өнөөгийн түвшний хувьд манай улстай ойролцоо болон өндөр хөгжилтэй улсууд ч бий. Манай бүлэг газарт Гүйцэтгэх захиралд зөвлөгөө өгөх 7-8 зөвлөх ажилладаг. Миний бие 2011 оноос хойш Захирлын зөвлөхөөр ажиллаж байгаа бөгөөд удахгүй гэрээт хугацаа дуусна.

-Гүйцэтгэх захирлын зөвлөх албанд нэлээд өндөр шалгуураар очсон байх даа?

сонгодог юм билээ. Тухайн улсын Засгийн газар өөрийн хүнээ санал болгодог гэсэн үг. Түүнийг нь Дэлхийн банкны холбогдох захиргааны газар нь нягталж, туршлага, мэдлэг бусад ур чадварыг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. Хамгийн гол нь ажилласан туршлагыг ихэд хардаг. Учир нь дэлхийн улс орнуудын бүхий л асуудлыг Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцдэг тул санал дүгнэлт өгөх хэмжээний, олон талын туршлагатай хүн байвал давуу талтай.

-Энэ хугацаанд Дэлхийн банкнаас манай улсад хандах хандлага ямар байсан бэ. Та хэр туршлага, мэдлэг хуримтлуулж авав?

-Сүүлийн жилүүдэд Олон улсын санхүүгийн корпорацийн үйл ажиллагаа Монголд нилээд өргөжиж байна. Тус корпорациас 100-гаад сая ам. долларын санхүүжилтийг шийдвэрлэсэн байгаа. Голдуу хувийн хэвшилд, тухайлбал, банк, санхүү,

ангиллаар бага орлоготой орны тоонд багтаж, зөвхөн хөгжлийн туслалцаа авч байсан. Олон улсын хөгжлийн ассоциациас урт хугацааны буюу 25-38 жилийн хугацаатай, эхний 10 жилдээ үндсэн зээлийг төлөхгүй байх, маш бага хүүтэй хөнгөлөлттэй зээлийг авч ашиглаж ирсэн. Харин 2012 оны долоодугаар сард Дэлхийн банкны шинэ ангиллаар манай улс дунд орлоготой орны түвшинд \ дунд орлоготой орны доод шатлалд\ багтсан. Ийм ангилалд багтангуут арилжааны зээл авах боломж шууд нээгдэхгүй.

Монгол Улс зах зээлийн хүү, нөхцөл бүхий арилжааны зээл авах, түүнийгээ эргэн төлөх чадамж бүхий орон болж байна. Энэ шилжилт нэг жилд бус 3-4 жилд аажмаар өөрчлөгдөж, улмаар хөгжлийн албан ёсны тусламжийг цаашид авах шаардлагагүй болно гэсэн үг.

Одоогоор Монгол улс зээл авах боломжийн хувьд холимог гэсэн



Дэлхийн банк. Вашингтон ДС.

Өнгөрсөн хоёр жилд явуулсан макро эдийн засгийн бодлогоо зайлшгүй эргэж харахгүй бол илүү уналтад хүрч магадгүй гэдгийг л Олон улсын валютын сангаас удаа дараа анхааруулсаар байна.

-Дэлхийн банкны үйл ажиллагааны цар хүрээ маш өргөн. Вашингтоны төв оффис нь УОУХОХБ, ОУХА, ОУСК зэрэг байгууллагын дүнгээр\ таван мянга гаруй ажилтантай. Үндсэн ажилтнаа олон нийтэд ил тод зарлаад өрсөлдүүлэх замаар сонгон шалгаруулж авдаг. Гүйцэтгэх захирлын зөвлөхийг тухайн улс орноос нь санал болгосноор, гэхдээ голдуу Сангийн яам, Төв банкны ажилтнуудаас

барилга угсралт, дэд бүтэц, зочид буудал, худалдааны салбарт хөрөнгө оруулалт хийжээ. Дэлхийн банк түлхүү нийгмийн хөгжлийн чиглэлд ядуурал, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин гэх мэт чиглэлээр техникийн туслалцаа, хөнгөлөлттэй зээл олгож хамтран ажилладаг.

Өнгөрсөн хугацаанд гарсан томоохон өөрчлөлт бол Монгол Улс 2012 оноос өмнө Дэлхийн банкны өөрийн

ангилалд багтаж байна. Өөрөөр хэлбэл, Монгол улс нэг талаар хөгжлийн албан ёсны туслалцаа авах боломж нээлттэй хэвээр байгаагийн зэрэгцээ анх удаа арилжааны нөхцөл бүрдлээ. Тухайлбал, зөвхөн техникийн туслалцаа биш, тодорхой томоохон төсөл дээр арилжааны зээлийг арай богино хугацаатай 15-20 жилээр ч юм уу авах нөхцөл бүрдэж байна. Энэ нь арилжааны зээл бөгөөд хүүний хувьд олон төрлийн нөхцөлтэй, ►

▶ тухайн үеийн зах зээлийн өгөгдлөөс хамаарч дунджаар “ЛИБОР + 0.6-1.35%” (LIBOR+0.6-1.3%) аргачлалаар тооцогдох хүүтэй зээл юм.

Зээлийг эргэн төлөх хугацааны хувьд урт, баталгаа, барьцаа шаардагдахгүй учраас улс орнуудын хувьд хөгжлийн тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд тун чухал санхүүгийн эх үүсвэр гэж үздэг. Энэ нь манайх шиг хөгжлийн тулгамдсан асуудал ихтэй улс оронд маш том боломж, санхүүгийн нэг чухал эх үүсвэр юм.

-Манай төр, засгийн удирдлагууд гаднаас их л зээл авч байна. Тэдэнд таатай л боломж байх?

-Дээрх ангилалд саяхан багтаж байгаа учраас зээлжих эрх одоо л нээгдэж байгаа. Зээлжих эрх нээгдэхийн тулд Дэлхийн банк 3-5 жилд явуулах хамтын ажиллагааны стратегийг эхлээд баталдаг. Манайх энэ бичиг баримтыг 2013 онд Захирлуудын зөвлөлийн хурлаар оруулж, шинэчлэн батлуулсан. Энэ үеэр Дэлхийн банкаас Монгол Улстай 2017 он хүртэлх хугацаанд хамтран ажиллах үндсэн чиглэлүүдийг баталсан байгаа. Энэ чиглэлүүдээ хэрэгжүүлэх ажил нь эхэлж байна. Дэлхийн банкны санхүүгийн жил нь хуанлийн жилтэйгээ давхарддаггүй. Зургаан сарын 30-нд дуусаад долдугаар сард дараагийн санхүүгийн жил нь эхэлдэг. Дэлхийн банкны 2015 оны санхүүгийн жил нь 2014 оны долдугаар сарын 1-нд эхэлсэн. Тэгэхээр Монгол Улс Дэлхийн банкаас арилжааны чанартай зээл авах чадамжтай болж байна гэсэн үг. Гэхдээ төслөө сонгох хэлэлцэх, үндсэн бичиг баримт бэлтгэх, батлуулах зэрэг ажилд багагүй цаг хугацаа шаардагдана.

Мөн энд хэд хэдэн асуудал бий. Тухайлбал, зээлдэгч улс орнууд зээлийн хязгаартай. Жишээ нь, 100 тэрбум ам.долларын ДНБ-тэй улсад нэг өөр, 10 тэрбумаар хязгаарлагддаг ДНБ-тэй улсад нэг өөр. Дэлхийн банк дотоод дүрмээрээ гишүүн орнуудынхаа оруулсан хөрөнгийн эзлэх хэмжээгээр нь хувийг тогтоосон байдаг. Манай улс бусад улс оронтой харьцуулахад ДНБ-ий хэмжээгээр харьцангуй бага, 10 гаруй тэрбум ам.долларт хүрч байгаа. Энэ хэмжээнээс хамаараад Монгол улсад ногдох зээлийн эрх, хуваарилалт нь 0.03 хувь байдаг. Хөгжлийн ижил

түвшинтэй бусад улстай нэгэн адил түвшинд гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тухайн нэг жилд авах зээлийн хэмжээ нь дээрх зээлийн шугамаас хэтрэх ёсгүй.

-Хэдий хэмжээний зээл авах боломжтой бол, манай улс?

-Энэ хэмжээг тоогоор шууд хэлэхэд амаргүй, энэ бол жил бүр өөрчлөгдөн тогтоогддог үзүүлэлт. Дэлхийн банк санхүүгийн жилдээ төсвийн хөрөнгийг гурван жилээр тооцоод ирэх жил хандивлагчдаас ийм хэмжээний хөрөнгө босго боломжтой гэсэн тодорхой мөнгөн дүнг тооцож гаргадаг. Тэр босгосон эх үүсвэрээс дээр дурьдсан квотоор бүс нутаг, улс орнуудад мөнгө хуваарилдаг. Олон улсын хөгжлийн ассоциациас манай улсын авах боломжтой зээлийн хязгаар одоогоор 30 орчим сая ам.доллар байгаа.

-Дэлхийн банк дэлхийн улс орон бүртэй ижил тэгш ханддаг уу?

-Дэлхийн банкны шийдвэр гаргах арга зам нь дүрэм журмаараа маш нарийн зохицуулагдсан байдаг. Ямар нэг ялгаварлах гэсэн юм байхгүй. Улс төрийн бус хөгжлийн байгууллага учраас. Ядуурлыг бууруулах нь энэ банкны үндсэн зорилго. “World free of poverty” буюу ядууралгүй дэлхий гэсэн үндсэн зорилгын төлөө ажилладаг. Ажилгүйдэл, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, хот байгуулалт, ногоон хөгжил зэрэг хөгжлийн бүхий л асуудал энд багтаж байгаа. Аливаа хөтөлбөр хэрэгжсэнээр тухайн улсын ажилгүйдэл, ядуурал хичнээн хувиар буурах боломжтой вэ, дэд бүтцийн хөгжилд нь хэр өөрчлөлт гарах уу зэрэг 10 гаруй шалгуур үзүүлэлтээр дүгнэдэг. Шалгуур үзүүлэлтээ жил бүр өөрчилдөг. Дэлхийн банкны мөнгө бол хөрөнгө оруулагчдаас бүрдүүлсэн эх үүсвэр учраас хөрөнгө оруулагчдын дуу хоолой шийдвэрлэх үүрэгтэй.

-Дэлхийн банкиг нэлээд шүүмжилдэг л дээ. Америкийн бодлогыг хэрэгжүүлэгч гэх мэтээр. Азийн хөгжлийн банкиг Японых гээд л.

-Оруулсан хөрөнгө оруулалтаасаа шалтгаалдаг. Дэлхийн банкинд Америк, Европын орнууд илүү хөрөнгө оруулсан. Азийн хөгжлийн банк бол бүс нутгийнх. Хөгжлийн банктай улс

орон олон бий. Бүс нутгийн банк дотор ч давамгай хөрөнгө оруулсан улс орны банк байгаа. Азийн хөгжлийн банкны хувьд Япон улс гол хөрөнгө оруулагч нь юм. Нэгдүгээрт, оруулсан хөрөнгө мөнгө, хоёрдугаарт, тухайн банкны удирдлагыг томилоход давуу хөрөнгө оруулсан улс нь түлхүү дуу хоолойгоо оруулдагтай холбоотой. Жишээлбэл, Олон улсын валютын сангийн захирлыг томилоход гол төлөв Европын орнуудаас сонгодог.

-Дэлхийн банкинд Америк 17 хувь эзэмшдэг гэдэг?

-Энэ хувь байнга өөрчлөгддөг. Хамгийн суулд 2010 онд жилийн уулзалт болсон. Хөгжингүй орнуудын дуу хоолой давуу байна гэсэн шүүмжлэлийг тус уулзалтаар ярилцаад хөгжиж буй орнуудын хувь оролцоог нэмэгдүүлж өөрчилсөн. Уг шийдвэрийн дагуу 30 гаруй орон дүрмийн сангаа шинэчлэн нэмэгдүүлсэн. Тэгэхээр аажимдаа хөгжиж буй орнуудын эзлэх хувийн жин, дуу хоолой сайн сонсогдож эхлэх байх аа.

-Одоо хоёулаа улс орны макро эдийн засгийн талаар ярилцъя. Учир нь таныг макро эдийн засгаар мэргэшсэн мэргэжилтэн гэж хэлж болно. Сангийн яаманд Макро эдийн засгийн газрыг хариуцан ажиллаж байсан. Одоо танай газрыг буулгасан байгаа. Бусад улсад Макро эдийн засгийн стратегийн төлөвлөгөө боловсруулдаг тусгай газар, хэлтэс байдаг юм байна. Та юу гэж үзэж байна вэ?

-Аль ч улс оронд хөгжлийн асуудлуудаа зөв бодлогоор судалж шийдвэрлэхийн тулд Макро эдийн засгийн стратегийн газар байх ёстой. Тухайн үед бид шилжилтийн эдийн засагтай байсан учраас жижиг эдийн засгийн хэт деталчилсан төлөвлөгөөтэй явж ирсэн. Төвлөрсөн төлөвлөлтөөс зах зээлийн эдийн засагт шилжсэн болохоор макро эдийн засгийн бодлого, төлөвлөлтийн ач холбогдол, үүргийг одоо ч манайхан сайн ойлгоогүй л байна. Хөгжлийн томоохон зорилтоо хэрэгжүүлэх арга зам нь макро эдийн засагтай зайлшгүй холбогддог. Улс орны эдийн засаг нь аливаа аж ахуйн нэгжийн түвшний асуудал биш. Олдсон хэдэн төгрөгөө аль өөрт таалагдсан дуртай ▶



Шинэ Зеланд, Камбож болон Номхон далайн арлуудын 14 улсын төлөөлөл нийлж, нэг бүлэг газар болж ажилладаг. Энэ бүлэгт Монгол Улс багтаж байгаа.

► зүйл рүүгээ хийгээд л хөгжинө гэж ойлгох ёсгүй. Хамгийн наад зах нь хөрөнгө оруулалтаа хэрхэн сонгох, ач холбогдолыг нь тогтоох, нийгэм, эдийн засгийн харилцан хамаарал, үр ашигтайгаар нь дарааллуулах гэх мэт макро эдийн засгийн бодлого зайлшгүй хэрэгтэй. Тухайлбал, хөрөнгө оруулагч Монголд хөрөнгө оруулах, мөн эсвэл буцааж гаргах нь эерэг болон сөрөг үр дагавартай. Бид үүний эерэг, сөрөг талыг сүүлийн жилүүдэд нилээд сайн мэдэрч байна.

Гадаадын хөрөнгө оруулалт орж гарч байгаа урсгал өөрөө цаашид эдийн засгийн олон салбарт нөлөөлдөг. Валютын ханш, валютын зах зээл, цаашлаад уул уурхай дагасан олон ажлын байр бий болгож байна, нөгөө талаар хөрөнгө оруулалт гарахад нь олон ажлын байр байхгүй болж байна. Тэгэхээр аль нэг талын эдийн засаг биш цаад гинжин холбоосуудыг харж, цаашид авч хэрэгжүүлэх бодлоготойгоо зөв уялдуулахад макро эдийн засгийн бодлого үндсэн арга хэрэгсэл нь болдог.

2012 оноос өмнө Сангийн яамны Макро эдийн засгийн бодлогыг газар 5-8 мэргэжилтэнтэй, макро эдийн засгийн бодлого дээр 4-5 хүн ажиллаж байсан. Энэ нь бүхэл бүтэн улсын хувьд дунд хугацааны

бодлого боловсруулахад хангалттай тоо биш. Бид урт хугацааны эдийн засгийн бодлого боловсруулах гэж оролдож байсан. Тухайн үеийн Засгийн газрын санаачлагаар Мянганы хөгжлийн зорилгод тулгуурласан үндэсний хөгжлийн цогц бодлогыг боловсруулсан. Мэдээж энэ бодлого дээр нэмж хасах, сайжруулах зүйл зөндөө байгаа. Гэхдээ энэ бол урт хугацааны бодлого зайлшгүй хэрэгтэй гэдэг тодорхой ойлголтод хүрсэн маш сайхан жишээ. Энэ бодлогыг цааш нь үргэлжлүүлээд, сайжруулаад аваад явах хэрэгтэй байсан гэдгийг одоо олон хүн хэлдэг. Хөгжлийн бодлого төлөвлөлт хэрэгтэй, энэ тухай хуультай болъё гэж ярьж байна. Бид хөгжлийн бодлогынхоо ач холбогдлыг ойр ойрхон алдсанаас болж их алдагдалд хүрч байна. Урт хугацааны бодлогоо тууштай авч явах нь маш чухал юм.

-Дэлхийн банкны төвөөс эх орондоо нүүрлээд буй эдийн засгийн хүндрэлийг та хэрхэн харж байна вэ?

-Түүхий эдийн экспортоос хэт хамааралтай манай улсын хувьд гадаад зах зээлийн нөхцөл байдал шууд хамааралтай. Эдийн засаг, үйлдвэрлэл хөгжөөгүй, уул уурхайн салбар нэг хэсэгтээ давамгайлсан

улс гадаад зах зээлээс олон талаар хамааралтай. Яг одоогийн байдлаар гадаад зах зээл дээр түүхий эдийн үнэ бууралттай хэвээр. Олон улсын судлаачдын хэлж буйгаар ойрын хоёр гурван жилд гол нэр төрлийн металлуудын үнэ өсөх хандлагагүй гэж таамаглаж байгаа нь манай эдийн засагт төдийлөн таатай үр дүн авчрахгүй. Бид зарим нэг түүхий эдийн гэнэтийн өсөлтөд их баярлах, хөөрөх хэрэггүй. Харин хөрш орнуудтай хийж байгаа гадаад худалдааны зөв бодлогодоо түлхүү анхаарах хэрэгтэй. Яагаад гэвэл гадаад худалдаанаас л бид валют, гадаад урсгалаа олж байгаа. Хамгийн зөв бодлого бол урт хугацаандаа эдийн засгаа төрөлжүүлэх зайлшгүй шаардлагатай. Төрөлжилт нь байшингийн хэлбэрийг өөрчлөх төдий асуудал биш учраас нэг, хоёр жилд бус, урт хугацаанд хийх асуудал. Нөгөө талаар хүмүүсийн ойлголтыг өөрчилнө. Урт хугацааны хөгжлийн болон макро эдийн засгийн бодлоготой байх нь хамгийн эхний зорилт гэдгийг дахин хэлмээр байна. Мөн гадаад зах зээлээс гадна дотоодын байдлаас эдийн засаг хүндэрсэн гэж үзэж буй хүмүүстэй санал нэг байна.

Өмнөх засгийн алдааг засаж, бодлогоо зөв болгоод цэгцлээд явах. Ялангуяа эдийн засгийн бодлого ►

▶ барьж байгаа хүмүүс юуны түрүүнд бодит байдалд зөв дүгнэлт өгөх ёстой. Бидний боломж юу вэ, баримталж буй бодлогохоо юуг нь засах ёстой вэ гэдгээ ойлгох хэрэгтэй. Энэ тал дээр олон улсын байгууллагууд манайд удаа дараа зөвлөмж өгч байгаа. Ялангуяа төсөв дээр тууштай бодлого баримтал, төсвөөс гадуур бүртгэж, үрэлгэн зарцуулалгүй аль болох тэргүүлэх ач холбогдолтой салбартаа хөрөнгө оруулалт хий гэдгийг олон улсын байгууллагууд байнга хэлж, зөвлөж ирсэн. Бодлогын хувьд өөрсдөөс хамаарах асуудал их бий. Мөн боловсон хүчний чадавхи. Төрөөс цөөн тооны боловсон хүчиндээ маш болгоомжтой хандаж тогтвортой, тууштай ажиллуулж, улам цааш нь дадлагажуулж мэргэшүүлж ажиллаасай. Гэтэл улс төрийн өнцгөөр хараад боловсон хүчнээ солих нь өөрөө улс орны хөгжилд маш

анхаарах ёстой.

Сүүлийн үеийн судалгааны бичиг баримтуудад хоёрдмол алдагдлын тухай ярьж байна. Төсөв, гадаад худалдаа нь алдагдалтай байгаа тохиолдолд мөнгөний бодлого тун хүнд байгаа. Валютын ханш чангарахаас өөр арга байхгүй. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай. Уул уурхайн салбар өсөх үед мөнгө олж, хуримтлуулж болж байна. Харин унахад хуримталсан мөнгө байхгүй байна. Тэгэхээр манай эдийн засгийн ямар салбар өсөлтийг, ямар салбар тэнцвэрийг бий болгож буйг харах хэрэгтэй. Бид зарим салбараа мартчихаад яваад байна. Улс орны бодлого л юм бол бүгдээрээ нэг тийшээ харчихаад уул уурхай, дэд бүтэц гээд ташуураад байж боломгүй.

Ялангуяа эдийн засаг ийм саармаг

өрийн талаар судалгаа өгсөн байсан. Жил бүр хийдэг өрийн тогтвортой байдлын судалгаагаар манай улсын макро эдийн засгийн бодлогын гол гол үзүүлэлтүүдийг гаргасан байгаа. Мөнгөний бодлогоос гадна Монголын өр санаа зовоосон асуудал боллоо. Эдийн засгийн бодлогуудын үр дүн таагүй гараад нэлээд хугацаа өнгөрчихлөө. Олон улсын судалгааны байгууллагууд манайд зөвлөгөө зөвлөмж өгснөөс хойш мөн л багагүй хугацаа авлаа. Гэтэл өнөөдөр асуудал намжаагүй байна гэдэг нь цаашид байдал улам л хүнд болно гэсэн үг. Тэгэхээр өнгөрсөн хоёр жилд явуулсан макро эдийн засгийн бодлогоо зайлшгүй эргэж харахгүй бол илүү уналтад хүрч магадгүй гэдгийг л Олон улсын валютын сангаас удаа дараа анхааруулсаар байна.

-Та эдийн засгаар мэргэшиж яваа залууст хандаж зөвлөгөө өгнө үү?

-Хувийн хэвшил, төрийн байгууллагуудад ажиллаж буй манай залуучууд ажлын байран дээрээ боловсрол, мэдлэгээ алхам тутамдаа дээшлүүлэх хэрэгтэй. Боловсролоо дээшлүүлнэ гэдэг нь зөвхөн онолын сурах бичиг унших, танхимд сууж сурах гэсэн үг биш л дээ. Нэгдүгээрт, гадаад хэлийг маш сайн сур, тэр дундаа мэргэжлийн гадаад хэлийг гүнзгийрүүлэн үзэж, бусад улс орны туршлагыг байнга уншиж судалж байх ёстой. Мөн улс орны тухайн цаг үеийн мэдээллийг уншиж судлаад өөрөө дүгнэлт хийдэг байх. Хэн нэгэн судлаачийн боловсруулсныг, дүгнэлт хийчихсэн бэлэн зүйлийг унших нь мэргэжлийн хүнд төдийлөн мэдлэг нэмэхгүй. Оюутнуудад бол бусдын гаргасан дүгнэлт, судалгаа маш их хэрэгтэй. Хятадын эдийн засгийн өсөлт яагаад саарч байна, Европын өрийн асуудал яагаад хүндэрсэн, Оросын эдийн засаг яагаад удаашралтай байна гэдэг дээр өөрийн хариултыг олох ёстой. Чиний хайж олсон хариулт чинь нэр хүнд бүхий олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас гаргаж буй судалгаа, дүгнэлттэй ойролцоо буюу нийлж байвал мэдлэг, туршлага чинь сайжирч байна гэсэн үг. Ингэж л өөрийгөө боловсруулах хэрэгтэй. Ялангуяа төрийн байгууллагынхан ийм чадварт суралцаж, шинийг байнга эрэлхийлэх нь залуучуудыг хөгжүүлнэ. ■

Манай эдийн засгийн ямар салбар өсөлтийг, ямар салбар тэнцвэрийг бий болгож буйг харах хэрэгтэй. Бид зарим салбараа мартчихаад яваад байна. Улс орны бодлого л юм бол бид бүгдээрээ нэг тийшээ харчихаад уул уурхай, дэд бүтэц гээд ташуураад байж боломгүй.

их сөргөөр нөлөөлж байгаа нь харагдаж байна.

-Эдийн засгаа сайжруулах өөр ямар боломж байна вэ?

-Эдийн засаг сайжрах гэдгийг тоо болон чанарын хувьд ярих ёстой. Тоон үзүүлэлтийг нэг, хоёр жилийн дараа гаргаж болох байх л даа. Чанарын хувьд бид алдаатай бодлогоо өөрчилж чадсан уу үгүй юу гэдэг хамгийн чухал. Жишээлбэл, алдагдалтай төсөв нэг, хоёр жилийн дараа алдагдалгүй болж болно. Энэ бол тоон үзүүлэлт. Гэхдээ цаана нь буй үрэлгэн зардал үнэхээр багасаж чадсан уу, төсвийн орон тоог тэлээд байгаа хууль тогтоомжууд хэвээрээ байна уу, үгүй юу. Энэ хамгийн чухал. Гадаад худалдааны алдагдал ч нөлөөлнө. Түр зуурын тоон үзүүлэлтэд хууртах хэрэггүй. Нэгэнт л бид дунд болон урт хугацааны тогтвортой тоон үзүүлэлтийн тухай ярьж байгаа бол илүү тогтвортой, чанартай өөрчлөлт болгох талд

байгаа үед дараагийн ажлын байрыг хадгалах салбараа дэмжиж байх ёстой. Жишээлбэл хөдөө аж ахуй. Эдийн засгийн ямар ч хямралын үед эдийн засгийг барьж тогтоож чаддаг, хүн амыг хүнд байдалд, хоол хүнсний дутагдалд орохоос хамгаалах хамгийн гол, тулгуур салбар бол хөдөө аж ахуй. Иргэдийн энэ тэргүүний хэрэгцээ болсон хүнсний хангамжийг нийлүүлж буй энэ салбар уналтад орвол юу болох вэ. Зөвхөн уул уурхай гэж хошуурахаасаа илүү уналтыг барьж байгаа суурь салбараа маш сайн дэмжиж, алсыг харсан бодлогоор хөгжүүлэх, тогтвортой хөрөнгө оруулалт хийдэг байх ёстой.

-Олон улсын валютын сангийн хүмүүс Монголд очиж, манай төр засгийн удирдлагуудтай уулзаж, эдийн засгийн бодлогоо эргэж харах зөвлөмж өгсөн?

-Саяхан Олон улсын валютын сан Дэлхийн банкинд Монгол Улсын гадаад

МӨНГӨНИЙ БОДЛОГО

ТӨГРӨГИЙН ӨГӨӨЖ

Б.БАЯРТОГТОХ

Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэдэх Мөнгөний бодлогын зөвлөл бодлогын хүүгээ өөрчилж, 12 хувь болгосон. Өмнө нь 10.5 хувиар хязгаарлаж байсан бодлогын хүүний “хүлээс” ийн тайлагдлаа. Ингэснээр уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжиж байсан зарим хөтөлбөр зогсонги байдалд шилжиж, бизнесийн эрч саарах шинж тэмдэг илэрсэн байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлтийг дэмжиж, тэлэх бодлого хэрэгжүүлж байсан Төвбанк эсрэг зүгт мордлоо. Зөөлөн мөнгөний бодлого инфляци ч нам түвшинд тогтоож дийлсэнгүй. Засгийн газартай нэг баг болж “ажилласан” Монголбанк хамтрагчаасаа хариуцлага шаардаж эхэллээ.

Мөнгөний бодлогын мэдэгдэлд “Төлбөрийн тэнцлийн хүндрэлийг зөөлрүүлэх, инфляцийг эрчимжүүлэхгүй байлгах, дунд болон урт хугацаанд санхүүгийн тогтвортой байдлыг хангах, макро эдийн засгийн тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, иргэдийн бодит орлогыг хамгаалах зорилгоор төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлсэн бодлогын энэхүү арга хэмжээг авч байна” хэмээн онцолжээ. Бодлогын хүү ийн өссөн нь арилжааны банкууд дахь зээл олгох сонирхол буурч, Монголбанкны үнэт цаасыг худалдан авах эрмэлзэл сэргэлээ. Эдийн засагт эргэлдэж буй мөнгөний эргэлт удааширч, үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн ханш ялимгүй чангарах хандлагатай болов.

Гэвч гадаад валютын хомсдолтой эдийн засагт төгрөгийн өрсөлдөх чадвар өдөр ирэх тусам суларсаар байна. Өөрөөр хэлбэл, Төвбанк бодлогын хүүгээ өмнөхөөс чангалсан ч инфляци тогтворжиж, ханшийн эрс хөдөлгөөнийг намжааж чадсангүй. Валютын ханшийг хүчээр барих боломжгүй гэдгийг Монголбанкнаас мэдэгдсэн. Өнөөгийн ханш Монголын эдийн засгийн бодит тусгал хэмээн тэд оношиллоо. Харин валют орж ирэх урсгалаа нэмэгдүүлж, дотоод боломжоо ашиглахын сацуу хэрэглээ, зарцуулалтаа багасгах зүй ёсны шаардлага тулгарч байгааг Эдийн засгийн ухааны доктор Э.Сандагдорж хэллээ. Тэрбээр “Эдийн засаг хүндэрсэн гол шалтгаан нь хуримтлалгүй, дархлаагүй, маш эмзэг эдийн засагтай явж ирсний үр дагавар” гэв. Валют нь экспортын орлого, гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад зээл гэсэн үндсэн гурван сувгаар эдийн засагт орж ирдэг аж. Мөн алттай орны хувьд алтаа олборлож, Төвбанкиндаа тушаавал тэр нь шууд гадаад валютын нөөц болдог. Энэ нь төгрөгөөр валютын нөөцөө нэмэх боломж юм.

Улсын хэмжээнд инфляци өнгөрсөн наймдугаар сарын байдлаар 13.7 хувьтай гарсан. Энэ нь зорилтот түвшингээс



20 жилд 29 мянга хүрээд гацсан ипотекийн зээл өдгөө 60 мянгад дөхжээ.

Фотог Б.Баяр

бараг хоёр дахин өндөр гарсан гэсэн үг. Монголбанкны хувьд энэ оны төрийн мөнгөний бодлогын үндсэн чиглэлд инфляцийг найман хувиас хэтрүүлэхгүй байхаар өөдрөг төсөөлсөн. Харамсалтай нь та бидний худалдан авах чадварыг тодорхойлох инфляци оны дундаас эрчимжтэй өссөн. Үүний эсрэг Төвбанк мөнгөний бодлогын хүүгээ хэвээр зүтгүүлсэн ч бодиттой амжилтад хүрээгүй. Тиймээс 10.5+1.5 хэмээх хувилбарыг сонгосон. Гэхдээ уужрах нэг шалтгаан бий.

Инфляци 13, 14 биш 40-50 хувьд хүрэх эрсдэл байсныг Монголбанкны Ерөнхий эдийн засагч, Ерөнхийлөгчийн зөвлөх С.Болд сануулсан удаатай. Хэрвээ үнэ тогтворжуулах хөтөлбөр байхгүй байсан бол инфляци дээш цогих байж. Мөн төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3000- ➤

▶ 4000 болох байсан. Түүнчлэн эдийн засгийн жинхэнэ хямрал нүүрлэж, улмаар 200 гаруй мянган хүн ажилгүй болох аюул байсныг тойроод гарчээ, манай улс.

Магадгүй эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээ авсан нь нэг талаар оносон байхыг үгүйсгэх аргагүй юм. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа “Төвбанк стандартын бус шийдлүүд гаргах гэж оролдсон. Тухайлбал, үнэ тогтворжуулах хөтөлбөр нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайтар мэдэрч, авсан сайн шийдвэр. Гэхдээ цаг хугацааны хувьд сунжруулсан” хэмээн дүгнэжээ. Стандарт бус мөнгөний бодлогын нэг багана нь үнэ тогтворжуулах хөтөлбөр. Түүний дараа орон сууцны ипотекийн зээл багтаж буй. Бүтэн 20 жилд 29 мянга хүрээд гацсан ипотекийн зээл өдгөө 60 мянгад дөхжээ. Хэдий эдийн засгийн зарим үзүүлэлт “өвдөг шороодсон” ч ипотекийн зээл тогтвортой хэрэгжиж буй.

Зээлийн тасалдал бий болж, банк дампуурч, таван төгрөгийн зээл тутмын нэг төгрөг нь чанаргүйдэж, эдийн засаг 1.3 хувиар агшиж, гуравхан сарын дотор 80 мянган хүн ажилгүй болж байсан 2009 оны бодит жишээ бий. Үүнийг өнөөдөр хэн ч давтагдаасай гэж хүсэхгүй байгаа. Гэвч 2011 онд ДНБ-ий 52 хувьтай тэнцэж байсан гадаадын хөрөнгө оруулалт өнгөрсөн онд 14, энэ онд долоон хувьд хүрсэн. Сүүлийн нэг жилийн хугацаанд хөрөнгө оруулалт хоёр дахин буурлаа. Нөхцөл байдал дээрдэхгүй байвал Монголбанк мөнгөний бодлогоо цаашид хатууруулах нь лавтай. Гэлээ ч хүлээсэн эерэг үр дүн эндээс гарахгүй байх эрсдэлтэй.

Мөнгөний бодлогын зөвлөл аажмаар бодлогын хүүгээ богино хугацаанд давтамжтай чангаллаа гэхэд хувийн хэвшлийнхэн үйл ажиллагаагаа хумихад хүрнэ. Үүний үр дүнд 2009 ондоо “эргэн очиж” мэдэх юм. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, нүүрсний үнэ сэргэж, томоохон төслүүд эдийн засгийн эргэлтэд орсон тохиолдолд бодит хүндрэлээс гарч чадна гэж албаны хүмүүс мэдэгдэх аж. Түүнээс зөвхөн мөнгөний бодлогын хүүгээр хүндрэлийг засна гэвэл өрөөсгөл болохыг С.Болд зөвлөх хэллээ.

Манай улсын хувьд хөрөнгө оруулалтын оргил үе 2011 он байсан. Энэ үед цэвэр дүнгээрээ 4.6 тэрбум ам.доллар орж ирсэн байдаг. Ингэснээр эдийн засаг 17.5 хувиар өсөж, улсын зээлжих зэрэглэл дагаад сайжирсан. Хүндрэлтэй эдийн засаг “Оюутолгой”-н далд уурхайн хөрөнгө оруулалтад ихээхэн найдлага тавьсаар байна. Он дамжин удааширч буй санхүүжилт энэ сард шийдэгдэх учиртай.

Өнгөрсөн жилийн мөн өдийд манайх 1.2 тэрбум гаруй ам.долларын шууд хөрөнгө оруулалттай байжээ. Тэгвэл дээрх хэмжээ одоо дөрөв дахин буураад байна. Өөрөөр хэлбэл, сард дунджаар 60 гаруй сая ам.долларын хөрөнгө оруулалт Монголд хийгдэх боллоо. Гэтэл 2011-2012 онд Монголд сар бүр 380 сая ам.долларын хөрөнгө оруулалт дунджаар орж ирдэг байв. Эндээс үзэхэд хөрөнгө оруулалт чамлахаар байгаа нь эдийн засгийн хөшүүн байдлыг улам өдөөх аж. ■

MONGOLIAN ECONOMY

ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН АНГЛИ, МОНГОЛ ХЭЛ ДЭЭР ХЭВЛЭГДДЭГ 14 ХОНОГ ТУТМЫН СЭТГҮҮЛ

РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

TEL: 7011-5476
www.mongolianeconomy.mn

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

“ЧИНГИС БОНД”-ЫН ЗАРЦУУЛАЛТ

С.АЗ

“Чингис” бондын хөрөнгийг ямар компаниудад өгсөн нь олон нийтэд төдийлэн ил бус байгаа. Тиймээс манай сэтгүүл “Чингис” бондоос ямар аж ахуйн нэгж хэдэн төгрөгийн зээл авсныг цувралаар хүргэж буй. Өмнөх дугаарт хөдөө

аж ахуйн салбар болон “Гудамж” төслийн зарцуулалтын талаар мэдээлсэн. Энэ удаа бид эрчим хүч болоод барилгын салбарт хэрэгжүүлсэн төслийн хүрээнд хэчнээн компанид хэдэн төгрөг өгснийг дэлгэрэнгүй нийтэллээ.

(тэрбум төгрөг)

Эрчим хүчний дэд бүтцийн төслүүд	
Хэрэгжүүлэгч	Эрчим хүчний яам
Тогтоолоор батлагдсан дүн	₮ 67,5
Гэрээний дүн	₮ 67,5
Олгосон дүн	₮ 57,1
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	65%

(сая ам.доллар)

Тавантолгойн ЦС, Эгийн голын УЦС	
Хэрэгжүүлэгч	ТТЦС (ЭХЯ) ЭГУЦС (ЭХЯ)
Тогтоолоор батлагдсан дүн	\$50.0
Гэрээний дүн	\$15,98 \$2,3
Олгосон дүн	\$14,8 (\$3,7) \$2,3
Эргэн төлөлтийн дүн	--
Ажлын гүйцэтгэл хувь	Бэлтгэл үе шат

(сая ам.доллар)

Тавантолгойн ЦС, Эгийн голын УЦС	
Хэрэгжүүлэгч	УУЯ
Тогтоолоор батлагдсан дүн	\$ 50.0
Гэрээний дүн	\$ 22,7
Олгосон дүн	(\$ 12,8)
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	-

(тэрбум төгрөг)

Дэд бүтцийн төслүүд	
Хэрэгжүүлэгч	ЭХЯ, БХБЯ
Тогтоолоор батлагдсан дүн	₮3.4
Гэрээний дүн	\$2.2
Олгосон дүн	\$2.1
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	100.0%

(тэрбум төгрөг)

Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор	
Хэрэгжүүлэгч	ҮХААЯ
Тогтоолоор батлагдсан дүн	₮ 14,2
Гэрээний дүн	₮ 9,2
Олгосон дүн	₮ 6,3
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	86,2%

(сая ам.доллар)

“Чингис хаан” БОИНГ-767 онгоц	
Хэрэгжүүлэгч	МИАТ ТӨК
Тогтоолоор батлагдсан дүн	\$ 115,0
Гэрээний дүн	\$ 84,2
Олгосон дүн	\$ 84,2
Эргэн төлөлтийн дүн	\$ 81,3
Ажлын гүйцэтгэл хувь	100%

(сая ам.доллар)

ТЭЦ-3 хүчин чадал нэмэгдүүлэх	
Хэрэгжүүлэгч	ЭХЯ
Тогтоолоор батлагдсан дүн	\$35,0
Гэрээний дүн	\$35,0
Олгосон дүн	\$28,0
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	86,2%

(сая төгрөг)

Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох 888 төсөл			
	Нийт 888 төсөл:	Экспортын төслүүд:	Импортын төслүүд:
Хүссэн санхүүжилт:	4,351.3	1,040.5	3,310.8
Төслийн нийт санхүүжилт:	7,624.4	1,541.1	6,083.4
Шинээр үүсгэх ажлын байрны тоо:	39,951	10,177	29,774
Төсөл өртгөө нөхөх хугацаа /сараар/:	55	52	55

(сая ам.доллар)

Дотоод барилгын арматур, төмрийн хүдрийн нойтон баяжмал үйлдвэрлэх дөрвөн төсөл			
Төсөл	Төсөл хэрэгжүүлэгч	Санхүүжилт	сая ам.доллар
Төмрийн хүдрийн нойтон баяжмалын үйлдвэр	"Монголросцветмет" ХК	Тогтоолоор батлагдсан дүн	\$ 12.10 (хүртэл)
		Гэрээний дүн	-
		Олгосон дүн	-
	"Мон-Лая" ХХК	Тогтоолоор батлагдсан дүн	\$ 6.40 (хүртэл)
		Гэрээний дүн	-
		Олгосон дүн	-
	"Монгол Метал Майнинг Холдинг" ХХК	Тогтоолоор батлагдсан дүн	\$ 8.80 (хүртэл)
		Гэрээний дүн	-
		Олгосон дүн	-
Барилгын арматурын үйлдвэр	"Бэрэнгруп" ХХК	Тогтоолоор батлагдсан дүн	\$ 22.70 (хүртэл)
		Гэрээний дүн	\$ 22.7
		Олгосон дүн	\$ 12.8

(тэрбум төгрөг, сая ам.доллар)

Төрийн орон сууцны корпорацийн төсөл	
Хэрэгжүүлэгч	ТОСК ТӨК
Тогтоолоор батлагдсан дүн	\$ 100.0
Гэрээний дүн	₮ 72.0
Олгосон дүн	₮ 72.0
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	94%

(тэрбум төгрөг, сая ам.доллар)

Төрийн банкаар олгох 6 хувийн мөргэйж	
Хэрэгжүүлэгч	Төрийн банк
Тогтоолоор батлагдсан дүн	₮ 80.0
Гэрээний дүн	₮ 80.0
Олгосон дүн	₮ 80.0
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	100%

(тэрбум төгрөг)

Яармагийн орон сууцны хороолол	
Хэрэгжүүлэгч	ПиАЙЭмЭМ ХХК
Тогтоолоор батлагдсан дүн	₮ 20.0
Гэрээний дүн	₮ 20.0
Олгосон дүн	₮ 12.2
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	40%

(сая ам.доллар)

"Хөтөл цемент шохой" ТӨХК өргөтгөл	
Хэрэгжүүлэгч	Бэйзмент ХХК
Тогтоолоор батлагдсан дүн	\$ 61.3
Гэрээний дүн	\$ 61.3
Олгосон дүн	\$ 61.3
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	100%

(сая евро)

Байшин үйлдвэрлэх комбинат (БУК-1) төсөл	
Хэрэгжүүлэгч	Эрэл ХХК
Тогтоолоор батлагдсан дүн	13.1
Гэрээний дүн	-
Олгосон дүн	-
Эргэн төлөлтийн дүн	-
Ажлын гүйцэтгэл хувь	30%



“ХӨГЖИЖ БУЙ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨСЛИЙН УДИРДЛАГА 2014”

ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ

Олон улсын төслийн удирдлагын институтын Монгол дахь салбар “PMI Mongolia Chapter” нь ирэх аравдугаар сарын 3-4-нд “Блю Скай” цамхагт “Хөгжиж буй эдийн засаг дахь төслийн удирдлага” нэртэй анхны олон улсын бага хурал, семинарыг зохион байгуулах гэж байна.

Хоёр өдрийн турш үргэлжлэх тус хурал нь Монгол Улс болон Ази-Номхон далайн хөгжиж буй эдийн засагтай орнуудын хувьд цаг үеэ олсон, чухал үйл явдал юм. Сүүлийн жилүүдэд Ази-Номхон далайн бүс нутаг дахь дэлхийн хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй нэмэгдсээр байгаа ба уг бүс нутгийн хувьд ирээдүйн чиг хандлага өөдрөг хэвээр байна.

Бага хурал нь Монголын шилдэг төслийн менежерүүдийн төслийн танилцуулгыг сонсох, Ази-Номхон далайн бүс нутгийн мэргэшсэн төслийн менежерүүдтэй туршлага хуваалцах, бие биенээсээ суралцах, танилын хүрээгээ тэлэх боломжийг бүрдүүлэх зорилготой.

“PMI Mongolia Chapter” байгууллага нь 2012 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд дэлхий даяар 700,000 гаруй гишүүнтэй олон улсын төслийн менежментийн “PMI” байгууллагын Монгол дахь салбар юм.

Та бүхэн бага хурлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл registration@pmimongolia.mn имэйл хаяг, 9509 0253 утсаар холбогдоорой.

DISCOVER MONGOLIA-2014

ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ БАЙРАА ЗАСЛАА

Б.ГАН

Уул уурхай Монголын эдийн засгийн хөдөлгөгч хүч гэдэгтэй одоогийн нөхцөл байдалд хүн бүхэн санал нийлж байна. Ийм цаг үед олон улсын хөрөнгө оруулагчдын “Дисковер Монголиа-2014” ээлжит чуулга уулзалт арван хоёр дахь жилдээ болж өнгөрлөө. Оролцогчдын цар хүрээ, ач холбогдлоо жилээс жилд өргөжүүлсээр ирсэн уг чуулга уулзалт энэ удаа бүл цөөтэй, дотоодод үүсээд буй асуудлаа түлхүү ярьсан хурал байв.

Энэ талаар чуулга уулзалтыг Зохион байгуулах хорооны дарга П.Очирбат “Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн найруулсан нь гадаадын хөрөнгө оруулагчдыг дэмжсэн явдал боллоо. БНХАУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр манайх Хятадын найман боомтод бүтээгдэхүүнээ гаргах боломж бүрдэж байна. Үндсэндээ гарцтай боллоо гэсэн үг. Мөн ОХУ-ын Ерөнхийлөгч транзит тээврийг гурван улс хамтарч шийдье гэсэн санал гаргасан. Ингэснээр бид таатай хуулийн нөхцөлтэй болсноос гадна далайд гарцтай болох боломж үүсч байна. Мөн тээврийн асуудлаа шийдсэн учир гадаадын хөрөнгө оруулалт наашлах хандлагатай болно. “Дисковер Монголиа” чуулган ч тооноос чанарт шилжиж байна” хэмээн онцоллоо.

Гадаадын хөрөнгө оруулалт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70 хувиар буурсан гэх мэдээллийг Монголбанкнаас өгөөд буй. Тус онд ДНБ-ий 53 хувьтай тэнцэж байсан гадаадын



Төр, хувийн хэвшил, иргэний нийгэмийн төлөөлөл хамтарч ажиллана

шууд хөрөнгө оруулалт одоо долоон хувьтай тэнцэх болсон байна. Тиймээс хөрөнгө оруулагчдыг татахын тулд манайх Хөрөнгө оруулалтын тухай хуулиа өнгөрсөн жил шинэчлэн баталсан. Харин УИХ-ын хаврын чуулганаар Ашигт малтмалын тухай болон Газрын тосны тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Мөн Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогоо тодорхойлсон гээд манай талаас хөрөнгө оруулагчдад дуулгах сайхан мэдээ олон бий.

Зохион байгуулагчдын зүгээс энэ удаагийн чуулганд хөрөнгө оруулагч дуудахаасаа өмнө дотооддоо асуудал, шийдлээ ярьж гэж зорьжээ. Тиймээс “Эрх зүйн орчин”, “Алт-нүүрсний өнөөгийн байдал”, “Төслийн санхүүжилт”, “Геологи хайгуул” сэдвээр хуралдсан юм. Мөн “Газрын ховор элемент” сэдэвт салбар хуралдаан болсон.

Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа “Уул уурхайн салбар өсөж, буурдаг. Энэ жамаараа явж байна. Ашигт малтмалын үнэ өндөр байхад гадаад, дотоодын хөрөнгө оруулагч олон байсан. Бид энэ удаагийн чуулганаараа хуулийнхаа хэрэгжилтэд өөрсдөө судалгаа хийж үзье гэсэн. “Дисковер Монголиа-2014” хоёр хөршийн төрийн Тэргүүний манай улсад хийсэн айлчлал болон Засгийн газар бодлогоо засах талаар ярьж эхэлж буй энэ үед болж буйгаараа онцлог байна” гэв.

Уул уурхайн яамнаас энэ салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгө оруулалт татахаар тодорхой ажлууд хийж эхэлжээ. Эхний ээлжинд 106 лицензэд сонгон шалгаруулалт хийж, сэргээхээр болоод буй. Хайгуулын лицензүүдийг ийн сэргээснээр 1-2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирэх тооцоо байгаа аж. Салбарын яам уул уурхайн салбарт төрөөс ▶

Уул уурхайн яамнаас салбарын үйл ажиллагаагаа идэвхжүүлэх, хөрөнгө оруулалт татахаар тодорхой ажлууд хийж эхэлжээ. Эхний ээлжинд 106 лицензэд сонгон шалгаруулалт хийж, сэргээхээр болоод буй. Хайгуулын лицензүүдийг ийн сэргээснээр 1-2 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт орж ирэх тооцоо байгаа аж.



► баримтлах гол шийдлүүдээ гаргасан гэж үзэж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд дэд бүтцийн асуудалд цаг хугацаа шаардах юм байна. Харин хайгуулын талбайд лиценз олгохоор сонгон шалгаруулалт зарлаад буй учраас хөрөнгө оруулагч орж ирэх бүрэн бололцоотой аж. Тиймээс ирэх онд “Дисковер Монголиа-2015” болох үед тодорхой үр дүн гарсан байна гэж яамны мэргэжилтнүүд тооцоолжээ.

Энэ жилийн чуулга уулзалтад Австрали, Канад, Малайз, Хятад, Хонконгийн хөрөнгө оруулагчид түлхүү оролцжээ.

Чуулганы үеэр хөндөгдсөн бас нэг чухал сэдэв нь “Монгол дахь хөрөнгө оруулалтын орчин сүүлийн гурван жилд хэрхэн өөрчлөгдсөн” талаарх MIBG компанийн гүйцэтгэх захирал, эдийн засагч А.Билгүүний танилцуулсан илтгэл байв. Тэрбээр хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэхийн тулд “Оюутолгой” төслийг урагшлуулах шаардлагатайг онцолсон. Монголд төдийгүй дэлхийд томд тооцогдох уг төслийг хөдөлгөх нь хөрөнгө оруулагчдад маш том итгэл найдвар төрүүлнэ гэдгийг ч яриандаа тодотгосон.

Харин салбарын яамны холбогдох удирдлагууд цаашид хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой гэдгийг хэлж байна. Энэ талаар Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүү “Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, энэ салбарын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор олон хууль, тогтоолыг манай яам боловсруулж, УИХ-аар

батлууллаа. Экспортын зах зээлд ч томоохон улс төрийн шийдлүүдийг хийж чадсан. Тиймээс оны сүүлч ирэх жилээс хөрөнгө оруулалт нэмэгдэнэ гэсэн хүлээлт байгаа. Зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр хоёр тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт орж ирэх боломжтой” хэмээв.

Чуулга уулзалтыг Уул уурхайн яам болон, Уул уурхайн үндэсний ассоциаци хамтран зохион байгуулсан. Энэ үеэр Монголын төр, хувийн хэвшил болон иргэний нийгмийн төлөөлөл “Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тунхаг бичиг”-т гарын үсэг зурлаа. Уг тунхаг бичгээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд уул уурхайн салбарт хариуцлагатай, ил тод, нээлттэй, байгаль орчныг дээдэлсэн үйл ажиллагааг эрхэмлэж явахаа бататгасан юм. “Төр, хувийн хэвшил, иргэний нийгэм гурвын оролцоо бол Монголын уул уурхайн салбарын тулгын гурван чулуу юм” хэмээн 2012 оны “Дисковер Монголиа”-гийн индрээс MIB группын ерөнхийлөгч Д.Жаргалсайхан онцолж байв. Түүний хэлснээр уул уурхайн салбарт тулгын гурван чулуу ийнхүү байраа заслаа. Энэ нь тус чуулганы онцлон тэмдэглэх үйл явдал байв.

УИХ хаврын чуулганы төгсгөлд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. “Дисковер Монголиа-2014” чуулганаар уг хуульд орсон өөрчлөлтийн талаар илтгэл танилцуулсан. Өөрөөр хэлбэл, Монголд батлагдаж байсан Ашигт малтмалын хуулиудын онцлог, энэ

салбарт хэрхэн нөлөөлж ирсэн талаарх ойлголтыг гаднынханд өгөх зорилготой байв. 2006 оны хуулиар маш олон тусгай зөвшөөрлийг цуцалсан. Гэхдээ өнгөрсөн хаврын чуулганаар баталсан Ашигт малтмалын тухай хуулиар алдаагаа засч, маргаантай байгаа 106 лицензийн асуудлыг шийдэхээр ажиллаж буй нь хөрөнгө оруулагчдын итгэлийг эргүүлэн олох чухал оролдлого гэдгийг Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч Н.Алгаа хэлсэн.

“Дисковер Монголиа-2014” чуулга уулзалтаар хөрөнгө оруулагчид Монголын уул уурхайн салбарын эрх зүйн орчин, алт болон нүүрсний зах зээлийн өнөөгийн байдал, хөрөнгө оруулалтын урсгал, шийдэл, геологи, хайгуулын эрх зүйн орчин гээд олон төрлийн мэдээллийг нэг дороос авсан юм.

Манай улсад 2011, 2012 онд 4.5-4.7 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирж байв. Харин энэ онд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг 750 сая ам.доллартай тэнцэнэ гэж зарим судалгааны байгууллага таамаглаж байна. Хэдийгээр 750 сая ам.доллар гэдэг 2011, 2012 онд орж ирж байсан хөрөнгө оруулалттай харьцуулахад маш бага тоо ч гэлээ Монголыг сонирхох гаднынхны урсгал буураагүйг илтгэх баримт юм. “Оюутолгой”-н далд уурхайн санхүүжилт нааштайгаар шийдэгдвэл түүнийг дагасан хөрөнгө оруулалтын урсгал Монголыг чиглэх нь дамжиггүй. Энэ нь манай эдийн засагт “түлхээс” болж, хүндэрлээс гарах том алхам болох юм. ■

БЯМБААГИЙН БУЛАН




“Мандал ассет менежмент” ХХК-ийн ерөнхийлөгч

МОНГОЛЫН БАНКНЫ ЗАХ ЗЭЭЛ БА БАНКУУДЫН СТРАТЕГИ

Банкны зах зээл ямар шатанд явна вэ?

Анхны арилжааны банкууд дөнгөж үүсгэн байгуулагдаж байсан үетэй харьцуулахад өнөөгийн банкны салбар Монголын санхүүгийн салбарт бат бөх байр суурь эзэлж, нэн чухал үүрэг гүйцэтгэх болсон. Хувийн хэвшил, бизнес, иргэдийн санхүүжилтийн эрэлт хэрэгцээний дийлэнх хэсгийг банкууд зээлээр хангаж ирсэн. Банкуудын активын хэмжээний ДНБ-д эзлэх хувь тогтмол өссөөр 2013 оны байдлаар 119 хувь буюу олон улсын дундаж түвшинтэй зэрэгцэж ирсэн байна.



Эх сурвалж: Монголбанк




Эх сурвалж: Монголбанк, УСХ, Мандалын тооцоолол

Жилээс жилд зээлийн хэмжээ тогтмол их хэмжээгээр өсч ирсэн бөгөөд зөвхөн санхүүгийн хямралын жил буюу 2009 онд буурч байжээ. 2004 оноос хойших статистикийг харвал жилд дунджаар 40 орчим хувиар өссөн байна. 2014 оны эхний хагасын байдлаар нийт зээлийн хэмжээ 12.4 их наяд төгрөгт хүрээд байна.

Зөвхөн дээрх үзүүлэлтүүд төдийгүй нэг хүнд ногдох банкуудын тоо, банкны харилцагчийн тоо, банкны карт эзэмшигчийн тоо зэрэг бусад статистикаас харахад Монголын банкны салбар нэлээд ханасан зах зээлийн төрөл рүү дөхөж байгаа нь харагдана.

Мөн манайх шиг жижиг зах зээлд банкуудын тоо хэт олон байгааг бүгд хүлээн зөвшөөрдөг. Сүүлийн жилүүдэд дөрвөн банк давамгайл байр суурь эзэлж ирсэн бөгөөд 2013 оны байдлаар нийт зах зээлийн 77 хувийг бүрдүүлж байна. Тэдгээрт дүн шинжилгээ хийж үзвээс, байгууллагын эсвэл иргэдийн зах зээл рүү илүүтэй хандсан банк гэдгээр л ялгагдахаас стратегийн онцлог тоглолт, зах зээлд эзлэх байр суурь ялгарч харагддаггүй. ▶



Эх сурвалж: Монголбанк

▶ Аливаа бизнесийн салбар ханана гэдэг нь өсөлтийн хувь саарч, тэлэлт төдийлөн явагдахгүй, зөвхөн бага зэргийн органик өсөлт гарах боломжтойг илтгэдэг. Банкны тухайд зээл олголтын өсөлтийн хувь үргэлжлүүлэн жилд 40 орчим хувиар өснө гэдэг эргэлзээтэй. Хэдийгээр зээл авах сонирхолтой этгээд олон байж болох ч, зээлийн шалгуурыг хангасан нь дийлэнх нь зээлээ авчихсан, харин бусад нь хангах боломжгүй байгаа тул шинэ зээлдэгчид олноор төрөх магадлал бага.

Зах зээл аажмаар ханаж байгаа нөхцөлд ирээдүйд банкуудын өрсөлдөөний үр дүн стратегиас нь ихэд хамаарч, зөв стратегиа тодорхойлж чадсан, өрсөлдөх чадвартаа анхаарч чадсан банк нь бизнесээ амжилттай үргэлжлүүлэн явуулах боломжтой болно.

Ийм нөхцөлд банкууд ямар стратегиар ажиллах нь зүйтэй вэ?

Нэгэнт зах зээл ханаж байгаа тул банкууд бизнесийн талбараа цаашид хэрхэн тэлж ажиллах вэ гэдэг асуулт гарч ирнэ. Үүнд нэг талаас уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчийг нэмэгдүүлэх, нөгөө талаас шинэ бүтээгдэхүүн, шинэ бизнесийн чиглэл нэмэх байдлаар хүрч болно.

Уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглэгчийг нэмэгдүүлж, зах зээл, харилцагчийн хүрээг тэлэхийн тулд өмнө нь зээл авч чадахгүй байсан компаниуд руу хүрч ажиллах, эсвэл одоо байгаа хэрэглэгчийнхээ зээлжих чадварыг нэмэгдүүлэх хэрэг гарна. Зээлжих чадварыг нэмэгдүүлэхийн тулд тэдгээрийн эрсдэлийг бууруулах, санхүүгийн түүх бүрдүүлэх, барьцаалбар үүсгэх, засаглалыг сайжруулах гэх мэт олон зүйл багтаж болно.

Банкны салбар нь санхүүгийн салбарт ганцаар ноёрхох нь өрсөлдөгчгүй, өрсөлдөөнгүй

байх давуу талтай мэт харагдаж болох ч бодит байдал дээр тийм биш юм. Учир нь, компаниуд хөрөнгө оруулалт, зээл гэсэн хоёр эх үүсвэрээс санхүүжиж байж сая санхүүгийн оновчтой бүтэцтэй болж санхүүгийн эрсдэл буурдаг. Зөвхөн банкны зээлийн эх үүсвэрээр компаниуд томорч, үйл ажиллагаагаа жигд явуулах хүндрэлтэй бөгөөд өртөг өндөр. Хөрөнгө оруулалтаар хэдий хэмжээний хөрөнгө татаж чадна, тэр хэмжээгээр компаниудын зээлжих, хөшүүргэдэх боломж нэмэгддэг.

Одоогоор Монголын бизнесүүд дийлэнх нь л банкны зээлтэй байдаг бөгөөд цаашид үргэлжлүүлэн зээл авах чадварт барьцаа хөрөнгийн хүрэлцээ, мөн өөрийн хөрөнгийн хэмжээ зэрэг нь гол хязгаарлалт болдог. Харин иргэдийн зах зээлийн хувьд, хэрэглээний, орон сууцны, жижиг бизнесийн зээл иргэдэд олгосон зээлийн дийлэнхийг бүрдүүлдэг. Цаашид хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэл, иргэний зээлийн түүхийн асуудал зээлжих боломжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх болно.

Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ эрэлхийлэх, нэвтрүүлэх тухайд мөн шинэ стратегиудыг боловсруулах нь зүйтэй. Бизнесүүдэд зөвхөн зээлийн санхүүжилт биш, шууд хөрөнгө оруулалт, бонд, лизинг, богино хугацаатай санхүүжилт гээд бусад олон төрлийн хэрэгсэл шаардлагатай. Зах зээлийн хэмжээг тэлэхийг тулд хэрэглэгчийн санхүүгийн эрэлт хэрэгцээг хангах офисын лизинг гэх мэт зээлийн шинэ төрлүүд гаргах талаар идэвхитэй эрэлхийлэх хэрэгтэй. Компанийн бондын зах зээл ч ирээдүйд улам сайн болж хөгжих ёстой. Мөн зээлээс бусад бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх ч мөн үүнд хамаарна. Тухайлбал, манай арилжааны банкууд хэдийнэ даатгалын бүтээгдэхүүн өөрийн салбараар дамжуулан борлуулах ажлыг эхлүүлээд байгаа билээ.

Шинэ бизнесийн чиглэл нэвтрүүлэх тухайд кастодиан, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, хөрөнгө оруулалтын банк, андеррайтер зэрэг олон чиглэл байж болох бөгөөд эдгээрийн хууль эрх зүйн үндэс тавигдсан. Мөн уул уурхай, дэд бүтцийн санхүүжилт, барилга, хөдөө аж ахуй, худалдаа гэх мэт аль нэг чиглэлээр дагнан мэргэших стратеги ч байж болох юм.

Дүгнэж хэлэхэд, зах зээлийн эрэлт хэрэгцээг даган үсрэнгүй хөгжиж байсан хэдий ч банкны салбар аажмаар ханасан зах зээл рүү дөхөж байгаа шинж тэмдгүүд илэрч байна. Ирээдүйд өрсөлдөөнд шалгарч үлдэж үргэлжлүүлэн бизнесээ тэлэхийн тулд Монголын банкууд шинэ стратегиуд боловсруулан ашиглах шаардлага тулгарч байна. ■



ЗОЧИН

“ӨНӨӨДӨР БОХИРДУУЛААД, МАРГААШ НЬ ЦЭВЭРЛЭЧИХЭЭР БАЯН БИШ”

Гэрэл зургийн МРА/Бямба-Очир

Б.ЭНХЦЭЦЭГ

НҮБ-ын Монгол дахь Суурин зохицуулагч, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч Сезин Синаноглу 2010 оноос Монголд ажиллаж амьдарч байна. Хэдийгээр өнөөдөр Монголын эдийн засаг хүндрэлтэй байгаа ч ард иргэд, эрх баригчид эдийн засгийн хүчтэй өсөлтийн замдаа эргэн ороход ихээхэн хичээл зүтгэл гаргаж байна гэж Сезин үзэж байна. Турк улсын уугуул тэрбээр Ойрхи

Дорнодын Техникийн Их сургуулийг Хот, бүсийн төлөвлөлтийн мэргэжлээр төгссөн байна. Сезин нь НҮБ-тай ажил амьдралаа холбоод 20 шахам жил болж буй. Туркменистан, Киргизстан, Турк зэрэг улсад томилогдон ажиллаж байжээ. Тус байгууллагад ажиллахаас өмнө тэрбээр АНУ болон Туркт хот төлөвлөлтийн чиглэлээр ажиллаж байжээ. Манай сэтгүүл түүнийг хүндтэй хүмүүсийг оролцуулдаг “Зочин” буландаа урьсан юм.

-Монголын хөгжилд оруулж буй НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд ямар салбар, чиглэлүүдийг голчилж байна вэ?

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нь Монголд хэрэгжээд нэлээд олон жил болж байна. Одоогоор бид 2012-2016 оны хооронд хэрэгжих хөтөлбөр дээр ажиллаж байна. Энэ нь гол гурван чиглэлтэй. Хүний эрх ба засаглал нэгдүгээр талбар бол хоёр дахь нь Мянганы хөгжлийн зорилтуудын биелэлт ба хүний хөгжил. Сүүлийнх нь байгаль орчны болон гамшгийн дараах нөхөн сэргээлт. Эдгээр чиглэлд бид Засгийн газартай голчлон

хамтарч байгаагаас гадна иргэний нийгэмтэй ч мөн хамтарч ажиллаж байна. Бидэнд өнөөдөр шинээр гарч ирж буй хэрэгцээнүүдэд анхаарлаа хандуулсан 11 хөтөлбөр бий. Гэвч улс орны хэмжээнд ямар сорилтууд шинээр урган гарч байгаад бид үргэлж нүд, чих тавьдаг. Тухайлбал, бид олон талын хэлэлцүүлгийн үр дүнд хотжилт нь бидний анхаарлаа хандуулах сэдэв мөн гэж тодорхойлсон байгаа. Хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж байх үед хотжилт нь тусдаа сэдэв байгаагүй. Бид жил бүр 4-5 удаа сэдэвчилсэн асуудлуудыг хөндөж, түүнтэй холбогдох хүмүүсийг сонгон оролцуулж, хөгжлийн хэлэлцүүлгийг

хийдэг. Хамгийн сүүлд бид Зам Тээвэр, Барилга хот байгуулалтын яамны сайд, Хотын дарга, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн бүсийн төлөөлөгч, хувийн хэвшлийн салбарын төлөөллүүдийг оролцуулан “Хотжилт”-ын хүрээнд хэлэлцүүлэг хийсэн байгаа.

-Та бүхэн энэхүү хэлэлцүүлгүүддээ иргэдийн оролцоог хэрхэн хангадаг вэ?

-Тухайн сэдэвтэй холбогдуулан санаа бодлоо хэлэхийг хүссэн иргэн, иргэний нийгмийн байгууллагууд гээд бүх хүмүүст хүрэхийг хичээдэг. Тухайлбал, бид ТББ-уудтай нэлээд ▶

▶ сайн хамтарч ажилладаг. Мөн зөвхөн манай анхаарлаа хандуулж буй гурван чиглэлээр хэлэлцүүлгийнхээ сэдвийг хязгаарладаггүй.

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэлхийн чиг хандлага өнөөдөр юу вэ?

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр гэлтгүй бусад олон улсын байгууллага хөгжиж бас өөрчлөгдөж байна. Дэлхий даяар олон өөрчлөлтүүд гарч байна. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн шинээр гаргасан Стратегийн төлөвлөгөө нь дэлхийн улсууд дахь Хөгжлийн хөтөлбөрийн офисуудын үйл ажиллагааг ерөнхийд нь чиглүүлж, суурь болдог. Тухайлбал, энэхүү ерөнхий чиглэлүүдийн нэг нь бүх түвшинд ядуурлыг үндсээр нь устгах. Үүнтэй уялдуулан нийгэмд шударга ёсыг авчирч, тэгш бус байдлыг хэрхэн халах асуудалд анхаарлаа хандуулж буй. Энэ бол хөтөлбөрийн нийтлэг

үндэсний тайлан дээр ажиллаж байна. Оны сүүлчээр олон нийтэд танилцуулж амжина гэж найдаж буй. Бид олон нийтийн сүлжээгээр дамжуулан залуусын ажилгүйдэл тэргүүтэй дэд сэдвүүдээр олон хэлэлцүүлэг өрнүүлж, иргэдийн санаа бодлыг сонсож буй.

-Хүний хөгжлийн индексийг улсын хөгжилтэй хэрхэн холбож ойлгож болох вэ?

Улсын ахиц дэвшлийг зөвхөн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээгээр тодорхойлон ойлгож болохгүй гэдгийг энэ үзүүлэлт харуулдаг. Тухайлбал наслалт, боловсрол бол суурь үзүүлэлт. Боловсрол эзэмших боломжоор иргэд хэр хангагдсан болох мөн боловсролын чанар ямар түвшинд байгааг харгалзана. Ерөнхийдөө хүмүүс боломжуудаар хэр хангагдаж, түүнийгээ ашиглаж чадаж байгааг

Одоогоор бид 2012-2016 оны хооронд хэрэгжих хөтөлбөр дээр ажиллаж байна. Энэ нь гол гурван чиглэлтэй. Хүний эрх ба засаглал нэгдүгээр талбар бол хоёр дахь нь Мянганы хөгжлийн зорилтуудын биелэлт ба хүний хөгжил. Сүүлийнх нь байгаль орчны болон гамшгийн дараах нөхөн сэргээлт. Эдгээр чиглэлд бид Засгийн газартай голчлон хамтарч байгаагаас гадна иргэний нийгэмтэй ч мөн хамтарч ажиллаж байна.

хоорондоо холбогдож буй шугам. Хоёрдугаар чухал бүрэлдэхүүн хэсэг нь тогтвортой хөгжил цаашлаад байгаль орчны тогтвортой байдал. Бас нэг чухалчлах зүйл нь уян хатан байдлыг бий болгох. Хүний үндсэн эрхүүдийг дээдэлж, иргэддээ санаа бодлоо хэлэх боломж олгодог, хуулиа дагадаг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнтэй болсон цагт дээрх төсөл хөтөлбөрүүд сайн хэрэгжинэ.

Шинэ стратегийн төлөвлөгөөгөө чиглүүлэн ажиллаж буй дөрвөн үндсэн талбар байна. Одоогоор бид залуус дээр суурьлан гаргахаар төлөвлөж буй хүний хөгжлийн

хүний хөгжлийн индекс тодорхойлж байгаа. Бид залуусыг цаашид байнгын анхааралдаа авах ёстой чухал бөгөөд эмзэг хэсэг гэж тодорхойлсон. Дэлхийн тайлангийн хувьд хүйсийн тэгш бус байдал хэмээх тусдаа индекс гаргадаг. Аливаа улсын хүн амын тал хувь хүртэх ёстой боломжоор хангагдахгүй байгаа бол улсын хөгжилд асуултын тэмдэг тавьж эхэлнэ.

-НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн голлох ололт бас алдаанууд юу байв?

-Бидэнд дурдах амжилт цөөнгүй бий гэж бодож байна. Манай хөтөлбөр

“Бичил-зээл” төслийг санаачилж, Хас банк өнөөдөр үүнийг аваад явж байна. Энэ санаачилга нь өнөөдөр нэлээд амжилттай яваа бөгөөд гаднын бусад оронд ч ийм төслүүд олноороо хэрэгжиж буй. Энэ нэг сайн жишээ нь.

Бид саяхан Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газар байгуулагдсаны 10 жилийн ойг тэмдэглэлээ. Энэ агентлаг нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн тусламжтайгаар байгуулагдаж байлаа. Монгол Улсад өөр удирдлагын агентлаг хэрэгтэй болох нь 2004 оноос тодорхой болж, бид Засгийн газартай хамтран хөтөлбөр эхлүүлж байсан. Бас нэг амжилтаа бид хуулийн зөвлөгөө өгөх төвүүд цаашлаад төрийн бус байгууллагуудаар дамжин хөгжсөн энэ төрлийн ойлголт хөгжүүлэлт гэж боддог. Энэхүү хуулийн зөвлөгөө өгөх төв нь ядуу иргэдэд хуулийн зөвлөгөө үнэ төлбөргүй өгдөг. Бид энэхүү үйлчилгээг санаачлан бий болгож, цаашид хөгжихөд нь тусалсан бөгөөд одоо Засгийн газар хариуцан авч явж байна. Одоо энэ нь бүрэн санхүүжилттэй улс даяар хэрэгждэг ажил. Дээр дурьдсан жишээ бол бидний хэрэгжүүлсэн олон хөтөлбөрүүдээс миний бахархаж явдаг гурав нь. Гэхдээ мэдээж бидэнд мөнгө санхүүжилтийн асуудлаас үүдэн төдийлэн хүссэн амжилт, түвшиндээ хүргэж чадаагүй зарим хөтөлбөр бий. Тухайлбал, жижиг дунд бизнесийг хөгжүүлэхтэй холбоотой зарим ажлын тухайд илүү их дэмжлэг хэрэг болж байгааг бид мэдэрсэн. Бид тодорхой бүлгүүдийг тэр дундаа мэргэжлийн ур чадвар хэрэгтэй байгаа эмэгтэйчүүдийг нэгтгэсэн. Тэднийг хүчтэй дэмжиж, тогтвортой бизнесийн үйл ажиллагааг бий болгохын тулд дахиад нэг алхмыг хийх хэрэгтэй байсан. Ингэхдээ бид сул талуудыг тодорхойлж, тэдний асуудлыг шийдэх зах зээлийг хөгжүүлэхэд хараагаа чиглүүлсэн юм. Бидний хэрэгжүүлдэг бүх төсөл хөтөлбөр тусдаа үнэлгээтэй бөгөөд үүн дээр үндэслэн хэрэгжилтийн шинэ шатанд шилждэг.

-Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх дэлхийн болоод бүсийн байр суурь юу байна вэ? Энэхүү зорилтын хүрээнд Монгол ▶

► Улс ямар түвшинд явж байгаа вэ?

Олон талтай асуудал. Дэлхий даяар баялаг нэмэгдсэн. Тухайлбал, Нигер улсыг аваад үзэхэд бүсийн хэмжээнд нэлээд хүчирхэгжиж байна. Энэ талаас нь харвал олон улс хөрөнгө мөнгөө нэмэгдүүлж чадсан. Гэвч баялгийн хүртээмжгүй байдал, ядуурал, эмзэг өртөмтгий байдлыг нь харвал ялгаанууд гарч ирнэ. Энэ жилээр МХЗ-ыг хэрэгжүүлэх хугацаа дуусч байгаа. Зарим орон чухал ач холбогдол бүхий үр дүн тухайлбал, ядуурал, ХДХВ-ын тархалтыг бууруулах зэрэг асуудлын хувьд нэлээд ахиц гаргаж чадсан. Ядуурлыг буурууллаа ч гэсэн цаана нь олон сая хүн ядуу амьдарсаар л байна. Энэ ядуурал гээчийг нэг мөр байхгүй болгож болох уу. Энэ бол 2015 оноос хойш бид яах вэ гэсэн хэлэлцүүлгийн гол сэдэв. Ирэх жил гэхэд МХЗ-ууд эцэслэгдэнэ. Тиймээс энэ бол бидний одоо ярих сэдэв. 2015 он гэхэд ядуурал одоо байгаагаас гаарвал яах вэ. Хоёрдугаарт, нийгмийн эрх тэгш байдал бөгөөд энэ нь ерөнхийдөө боломжуудаар хангагдах тухай асуудал. Гуравдугаарт, байгаль орчин. Хэрвээ бид өнөөдөр л тогтвортой ногоон замналыг сонгохгүй юм бол, маргааш гэхэд дэндүү оройтсон байх болно. Ямар ч улс өнөөдөр бохирдуулаад, маргааш цэвэрлэхчхдэг тийм баян биш. Өнөөдөр дэлхий даяар “Тогтвортой хөгжлийн зорилтууд” хэмээх шинэ багц зорилтуудыг хэлэлцэж байна. Одоогоор энэ хүрээнд 17 зорилтыг тодорхойлоод байна.

Монгол Улсын хувьд МХЗ-ын ач холбогдлыг таньж чадсан улс. Тухайлбал, МХЗ-д суурилсан хөгжлийн стратеги гарсан байдаг. Мөн үндэсний хөгжлийн стратегиудад ч мөн тусгалаа олсон байдаг. Засаглал, хүний эрхийн хүрээнд МХЗ-ыг тодорхойлж дэлхийд танилцуулсан орон бол Монгол. Мөн эдгээр зорилтуудын биелэлт, явцыг хянаж байна.

-Монголын Засгийн газар болон НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр хамтарснаар гарсан гол үр дүнгүүдийг та юу гэж бодож байна вэ?

-Монгол Улс МХЗ-уудын хүрээнд

Монгол Улс Монголын хөгжлийн зорилтын хүрээнд тав дахь тайлангаа өнгөрсөн жил боловсруулсан. Үүнээс харахад 24 зорилтот асуудлын 3-4 нь тодорхой үр дүнд хүрсэн нь илт байна.



тав дахь тайлангаа өнгөрсөн жил боловсруулсан. Үүнээс харахад 24 зорилтот асуудлын 3-4 нь тодорхой үр дүнд хүрсэн нь илт байна. Заримынх нь үйл явц дуусаагүй. Тухайлбал, хүнс тэжээлийн хомсдолд өртөж буй хүмүүсийн тоо буурч байгаа бөгөөд зорилтдоо хүрэх замдаа явж байна. Мөн нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг хүртээмжтэй болгох тал дээр хийгдэж буй ажил урагштай байгаа. Миний бодлоор эмэгтэйчүүдийн улс төр дэх оролцоо, эрх мэдлийг нэмэгдүүлэх нь Монгол Улсын зүгээс хийх ёстой чухал ажил. Мөн хүн бүрийн эрүүл мэндэд нөлөөлж буй агаарын бохирдол бол

шийдэгдээгүй, зорилгодоо хүрээгүй бас нэг том асуудал юм.

-Хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тодорхой зорилт тавьсан хэсгүүдэд хийгдэж буй санхүүжилтийн зорилт биелсэн эсэхээс үл хамаарч хугацаа нь дуусмагц зогсоодог уу. Эсвэл санхүүжилтийг сунгадаг уу?

-Бидний хөтөлбөрийн хүрээнд өөрсдийн гэсэн долоон сая ам.долларын санхүүжилт мөн дээр нь хамтрагч болон доноруудын зүгээс орж ирж болох 21 сая ам.долларын эх сурвалж бий. Бид нэмэлт санхүүжилтийг өсгөх тал дээр ихээхэн ахицтай ажиллаж байгаа. Одоогийн хөтөлбөрийн хүрээнд огт санхүүжилтгүй ямар ч хэсэг байхгүй. Харин санхүүжилтийн хувьд хангалттай бус байгаа нь бол бий. Өмнө нь хэлсэнчлэн шинээр гарч ирж буй асуудлууд тухайлбал, хотжилт, олборлох үйлдвэрлэлийн ажлын байрны өсөлт зэрэг юм. Олборлох үйлдвэрлэлийн хувьд ямар ч шатанд нь хүний хөгжлийн асуудлыг тусгаж өгөх нь зүйтэй. Бид энэ хүрээнд заавал мөнгө босгох ёстой гэж үзнэ. Одоогоор бидэнд ихээхэн сэтгэл зүтгэл байгаа ч, санхүүжилт байхгүй байна. Гэвч энэ нь хэсэг хугацааны дараа шийдэгдэх зүйл. Энд дурьдах ёстой чухал хөгжлийн үзүүлэлт байна. Монгол бол өнөөдөр багдунд орлоготой орон. Дэлхий даяар НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрүүдийн санхүүжилтийн 22 хувь нь үнэндээ Засгийн газруудын өөрсдийн нөөц хөрөнгөөс гарсан байдаг. Өөрөөр хэлбэл, Засгийн газар хамтран санхүүжүүлэгчээр ажилладаг гэсэн үг. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй хөтөлбөрүүдэд олон сая ам.доллар өгдөг орнууд ч бий. Монгол энэ тухайд эхний алхмаа хийж байна. Бид заавал гуравдагч орон, эх сурвалжаас мөнгө хайх, олох шаардлага байхгүй. Монгол өөрөө мөнгөтэй орон. Улс орны хувьд нэн тэргүүний чухал асуудлууд хэмээн санал нэгдэж, хамтдаа гарын үсэг зурсан. Бид одоо бол бие биенийхээ хүчин чармайлтыг дэмжин, аль, аль талаасаа дутуугаа нөхөж л ажиллаж байгаа. Энэ л бидний Монголын нөхцөлд улам батжиж цаашаа яваасай гэж бодож буй үйл ажиллагааны загвар. ■



Хариуцлагын Даатгал Таны Төлөө

Манай улс 2012 оноос жолоочийн хариуцлагын даатгал гэдэг бүтээгдэхүүнийг борлуулж эхэлсэн боловч замын хөдөлгөөнд идэвхтэй оролцогч даатгуулагчдын 93 хувь нь энэ даатгалд хамрагдаж, зам тээврийн ослын улмаас хохирсон иргэд, байгууллага 2013 онд 19,216 даатгалын тохиолдолд 10 гаруй тэрбум төгрөг, 2014 оны эхний 8 сард 12,292 даатгалын тохиолдолд 6,4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалаас олгоод байна.



УЛААНБААТАР
ХОТЫН
ДААТГАЛ



ГЭР ДААТГАЛ
Үндэсний даатгалын компани



АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО
УТАС: 70101177, 70121177
www.ami.mn, info@ami.mn

АГЕНТЛАГУУДЫН БҮТЭЦ

С.А3

Ард иргэдийн амьдрал ямар байх нь төр засгийнх нь бодлого, шийдвэрээс ихээхэн хамаарч байна. Улс төрийн хүрээнд гарч

буй зарим алдаатай шийдвэр бидний амьдралд алхам тутамд мэдрэгдэж буй. Тиймээс бодлого тодорхойлоход оролцож буй төрийн албаны “боссууд” ямар мэргэжилтэй болохыг

	АГЕНТЛАГ		ДАРГА	ДЭД ДАРГА
	№	Газар	Нэр: Мэргэжил:	Нэр: Мэргэжил:
АГЕНТЛАГУУДЫН БҮТЭЦ	1	Архивын ерөнхий газар	Нэр: И.Саруул Мэргэжил: Түүхч	Нэр: С.Д.Өлзийбаатар Мэргэжил: Түүхч Нэр: Г.Билгүүн Мэргэжил: тодорхойгүй
	2	Ашигт малтмалын газар	Нэр: Д.Үүрийнтуяа /үүрэг гүйцэтгэгч Мэргэжил: эдийн засагч, нийгмийн удирдлагын менежер	Одоогоор дэд дарга нь даргын үүрэг гүйцэтгэж байгаа
	3	Гаалийн ерөнхий газар	Нэр: О.Ганбат Мэргэжил: Орос хэлний багш, нягтлан бодогч, эдийн засагч	Нэр: Н.Энхцогт Мэргэжил: Геологич-инженер Нэр: Ц.Уугангэрэл Мэргэжил: Хуульч
	4	Газрын тосны газар	Нэр: Г.Өлзийбүрэн Мэргэжил: Эдийн засагч, эрх зүйч	Нэр: Ц.Амраа Мэргэжил: тодорхойгүй
	5	Газрын харилцаа, геодези зураг зүйн газар	Нэр: А.Хүрэлшагай Мэргэжил: Инженергеологич, гидрологич	Нэр: Ж.Даваабаатар Мэргэжил: Газар зохион байгуулагч
	6	Зэвсэгт хүчний жанжин штаб	Нэр: Ц.Бямбажав Мэргэжил: Москва хотын цэрэг-улс төрийн академи төгссөн	Нэр: Б.Баярмагнай Мэргэжил: тодорхойгүй
	7	Иргэний нисэхийн ерөнхий газар	Нэр: Т.Лхагвасүрэн Мэргэжил: Агаарын хөлгийн авионик инженер	Нэр: С.Энх-Амгалан Мэргэжил: Рига хотын нисэхийн дээд сургууль төгссөн Нэр: Ч.Нямсайхан Мэргэжил: ЗХУ-ын Сасово хотын нисэхийн дунд сургууль, Санкт-Петербург хотын Нисэхийн академи төгссөн
	8	Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар	Нэр: Б.Пүрэвдорж Мэргэжил: Гадаад харилцаа	Нэр: Б.Цолмон Мэргэжил: Эрхзүйч Нэр: М.Мөнхбат Мэргэжил: Хуульч
	9	Мал эмнэлэг, үржлийн газар	Нэр: М.Галбадрах Мэргэжил: Зоотехникч, эдийн засагч	Нэр: П.Болортуяа Мэргэжил: Малын их эмч, эпидемиологич Нэр: Н.Батжаргал Мэргэжил: Зоо-инженер
	10	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар	Нэр: Ц.Жадамбаа Мэргэжил: Хуульч	Нэр: З.Энхболд Мэргэжил: Санхүү-банкны эдийн засагч, магистр
	11	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	Нэр: Д.Батмөнх Мэргэжил: Эрхзүйч, орчуулагч	Нэр: Гүнбазар Мэргэжил: Барилгын зохион бүтээгч, инженер Нэр: Б.Эрдэнэбилэгт Мэргэжил: Механик инженер
	12	Нийгмийн даатгалын ерөнхий газар	Нэр: Ц.Уртнасан Мэргэжил: -	Нэр: О.Байгальмаа Мэргэжил: -
	13	Нийгмийн халамж, үйлчилгээний газар	Нэр: Д.Баярсайхан Мэргэжил: Архитектор, эрхзүйч, эдийн засагч	Нэр: Ц.Алтанчимэг Мэргэжил: Багш, төрийн удирдлагын магистр Нэр: Б.Цэндсүрэн Мэргэжил: Философи, төрийн удирдлага
	14	Онцгой байдлын ерөнхий газар	Нэр: Т.Дуламдорж Мэргэжил: Хуульч	Нэр: Т.Бадрал Мэргэжил: - Нэр: Дарь.Сүхбаатар Мэргэжил: Физик, математикийн багш, сэтгүүлч

манай сэтгүүл хүргэж буй. Бид өмнөх дугаартаа Засгийн газрын бүтэц, яамдын удирдлагуудын ажил мэргэжлийг танилцуулсан билээ. Харин энэ удаа агентлагуудын дарга,

дэд дарга, газруудын талаарх мэдээллийг хүргэж байна. Шинэчлэлийн Засгийн газар 29 агентлагтай. Эхний ээлжинд 14 агентлагийг танилцуулъя.

ГАЗАР ХЭЛТЭС

1. Тамгын газар 2. Мэргэжил, арга зүйн удирдлагын газар 3. Мэдээлэл, үйлчилгээний удирдлагын газар	4. Сургалт, судалгааны газар 5. Санхүү, аж ахуйн хэлтэс	1
1. Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, 2. Геологийн алба, 3. Уул уурхайн хэлтэс, 4. Нүүрсний хэлтэс	5. Кадастрын хэлтэс 6. Хяналт шинжилгээ үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэс 7. Уул уурхайн шинжилгээ туршилтын лаборатори	2
1. Төрийн захиргаа, удирдлагын газар 2. Хууль сахиулах, худалдааг хөнгөвчлөх газар 3. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	4. Гаалийн татвар, тарифын газар	3
1. Захиргаа удирдлагын хэлтэс 2. Эдийн засаг, санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс 3. Ашиглалт олборлолтын хэлтэс 4. Гэрээлэлт, хайгуул судалгааны хэлтэс	5. Хангамжийн зохицуулалтын хэлтэс 6. Үйлдвэрлэл, техник технологийн хэлтэс 7. Хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс 8. Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лаборатори	4
1. Захиргаа, санхүүгийн алба 2. Газрын удирдлагын алба 3. Орон зайн мэдээллийн дэд бүтцийн алба		5
Төрийн маш нууц зэрэглэлд хамаардаг. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 46 дахь хэсэгт "Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил	эрхэлдэг байгууллагын бүтэц, зохион байгуулалт, орон тоо, гүйцэтгэх ажлын төсөв, зардал, тэдгээрт холбогдох баримт бичиг" маш нууц зэрэглэлд багтдаг байна.	6
1. Захиргаа удирдлагын газар 2. Санхүү, эдийн засгийн газар 3. Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтын газар, 4. Агаарын навигацийн үйлчилгээний газар	5. Нисэх буудлуудын үйлчилгээний газар 6. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тасаг	7
1. Тамгын хэлтэс 2. Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтэс 3. Албадан гаргах хэлтэс 4. Харьяалалын хэлтэс	5. Мэдээлэл технологийн хэлтэс 6. Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс 7. Хангалт үйлчилгээний хэлтэс	8
1. Мал эмнэлгийн хэлтэс 2. Мал үржлийн хэлтэс 3. Захиргаа санхүүгийн хэлтэс		9
1. Шинэчлэлийн бодлого, төлөвлөлтийн газар 2. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3. Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар	4. Хяналт-шинжилгээний газар 5. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	10
1. Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын газар, 2. Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэр, үйлчилгээний хяналтын газар, 3. Эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын газар 4. Дэд бүтцийн хяналтын газар	5. Байгаль орчин, аялал жуулчлал, геологи уул уурхайн хяналтын газар 6. Хилийн мэргэжлийн хяналтын газар,	11
1. Тамгын газар 2. Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газар 3. Санхүү бүртгэлийн газар	4. Хяналт, шинжилгээ үнэлгээний газар 5. Санхүү бүртгэлийн газар 6. НДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын газар	12
1. Тамгын газар 2. Нийгмийн халамж үйлчилгээний газар 3. Хүн амын хөгжийн газар	4. Санхүү, бүртгэл төлөвлөлтийн газар 5. Хяналт-шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газар	13
1. Тамгын газар 2. Бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газар		14

Үргэлжлэл бий

ЭРДМИЙН ШУВУУ

ЦАЛИН ХӨЛСНИЙ ЯЛГАВАРТАЙ БАЙДЛЫГ ТООЦОХ АСУУДАЛД

Манай сэтгүүлийн редакцийн утасны ачааллын нэлээд хэсгийг Эдийн засаг, бизнесийн чиглэлийн их, дээд сургуульд сурч байгаа ахлах дамжааны оюутнууд болон эрдмийн зэрэг цол горилж буй хүмүүс эзэлдэг. Тэд судалгааны ажил болон эрдмийн бүтээлийнхээ талаар манай сэтгүүлд гаргуулах маш их хүсэлтэй байдаг. Угаасаа ч цаанаас нь эрдмийн ажлынхаа талаар сонин хэвлэлд материал заавал гаргуулсан байна гэж шаарддагийг бид мэднэ. Тиймээс энэхүү хүсэлт, хэрэгцээг харгалзан үзэж манай сэтгүүл энэ дугаараасаа “Эрдмийн шувуу” нэртэй булан нээлээ. Оюутан сурагчдад хандан хэлэхэд, бидний тавьсан шаардлагын дагуу эрдмийн бүтээлээ ирүүлж болно. Мөн их, дээд сургуулийн оюутнуудын дунд зарласан шилдэг илтгэл, судалгааны ажилд шалгарсан бүтээлийг тавих боломжтой.



Г.ЧУЛУУНЦЭЦЭГ /ХААИС-ИЙН ЭЗБС-ИЙН АХЛАХ БАГШ, ДОКТОРАНТ/

Оршил

Үр тарианы үйлдвэрлэл эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн ажилчдын дундаж цалин харилцан адилгүй байна. “Цалин хөлс гэж ажилтныг ажилд авсан тухай амаар болон бичгээр байгуулсан гэрээний дагуу түүний хийж гүйцэтгэсэн эсвэл хийж гүйцэтгэвэл зохих ажил үйлчилгээнийх нь төлөө ажил олгогчоос үндэсний хууль тогтоомж гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр тогтоон олгож буй аливаа мөнгөн урамшуулал буюу ажлын хөлсийг хэлнэ” гэж Олон улсын

хөдөлмөрийн байгууллагын Цалин хөлс хамгаалах тухай 95-р конвенцид тодорхойлсон байдаг.

Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн тухай 47-р зүйлд “Цалин хөлс нь үндсэн нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал гэсэн хэсгүүдээс бүрддэг” хэмээн хуульчилсан байна.

Илүү хариуцлагатай ажилд өндөр цалин төлөх ёстой гэсэн үзэл баримтлал нийтлэг байдаг. Иймээс удирдлагын төвшин ахих тусам зэрэглэл хоорондын зөрүү нэмэгддэг. Тухайлбал, олон улсын практикт голдуу 15-20 хувийн

зөрүүтэй цалингийн бүтцийг анхан шатны менежерүүдэд эсвэл ажилчдад, 20-40 хувийг дунд түвшингийнхэнд, хариуцлагын цар хүрээ их байдаг дээд шатны менежерүүдэд 40-60 хувийн зөрүүтэй цалингийн бүтцийг хэрэглэдэг байна. Харин цалингийн ялгавартай байдал гэдэг нь хамгийн бага цалин, хамгийн их цалин хоёрын хоорондын зөрүүний тухай ойлголт юм. Дэлхийн улс орны болон Монголын, Сэлэнгэ аймгийн газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 52 аж ахуйн нэгжийн 545 ажилчдын цалин хөлсний ялгаварт байдлыг судалж үзлээ. ▶

Цалин хөлсний ялгавартай байдлыг судалсан судалгаа

(Сэлэнгэ аймгийн газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжийн жишээн дээр, 2013 оны байдлаар), хүснэгт 1

Сарын дундаж цалин, мян.төг	Ажилчдын тоо	X_i	F_i	P_i	Нийт цалингийн фондод эзлэх хувь, Q_i	$P_i Q_i + 1$	$P_i + 1 Q_i$
139,6-227,7	122	183,7	122	22,4	0,133	10,998	-
227,7-315,8	223	271,8	345	63,3	0,491	47,411	8,418
315,8-403,9	122	359,9	467	85,7	0,749	70,359	42,078
403,9-492,1	27	448	494	90,6	0,821	83,533	67,859
492,1-580,2	32	536,1	526	96,5	0,922	89,648	79,226
580,2-668,3	2	624,2	528	96,8	0,929	96,800	89,249
668,3-756,4	17	712,3	545	100	1,000	-	92,900
Нийт	545					398,749	379,730

2013 оны байдлаар Сэлэнгэ аймгийн газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн ажилчдын цалин 311,2 мянган төгрөг байна. Үүнийг улсын дундаж, бүсийн дундаж, салбарын дундаж, аж ахуйн нэгж байгууллагынх нь өмчийн хэлбэрээр харьцуулахад дараах дүн гарч байна.

100 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг харьцуулан судалж үзэхэд: Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн ажилчдын дундаж цалин 311,2 мянган төгрөг, аймгийн дундаж цалин 468,4 мянган төгрөг бол хөдөө аж ахуйн салбарын дундаж цалин 302,6 мянган төгрөг мөн улсын дундаж цалин 627,2 мянган төгрөг байна.

Дүгнэлт, санал

- Газар тариалангийн төвийн бүс нутаг Сэлэнгэ аймгийн улаан буудай үйлдвэрлэл эрхэлдэг 52 аж ахуйн нэгж байгууллагын 545 ажилтны цалин хөлсний ялгавартай байдлыг дицелийн аргаар судалж үзэхэд 2.7 дахин их байгаа боловч жени коэффициент, Лоренцын муруйгаар тооцож үзэхэд 0.19 гарч цалин хөлсний ялгавартай байдал байхгүй байгаа нь батлагдлаа.
- Цалин хөлсний судалгааг хийхдээ жигд үйл ажиллагаа явуулсан нийгмийн даатгал шимтгэл тогтмол төлдөг аж ахуйн нэгжүүдийг хамруулсан.

тайлангаас харагдаж байна.

- Газар тариалангийн ажиллах хүчтэй холбоотой дараах хүндрэл бэрхшээл гардаг байна. Үүнд: мэргэжлийн ажиллах хүч дутагдалтай, ажиллах хүчний тогтвор сууршил муу, ажилтнуудын ажлын хариуцлага сул, ажиллах нөхцөл хангагдаагүй, хөдөлмөрийн гэрээ, хамтын гэрээг тогтмол хийдэггүй дутагдал байна.

Санал

- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг/ХХДХ/ тогтоохдоо бүс нутгаар ялгавартай тогтоовол ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ. Олон улсын практикт ХХДХ-г бүс нутгаар ялгавартай тогтоох хандлага дийлэнх байна. Энэ нь ялангуяа улирлын шинж чанартай ажил эрхэлдэг ажилчдад эерэг нөлөө үзүүлэх зорилготой.
- Тариаланчид гол төлөв тогтмол цалингийн хэлбэрээр цалинжиж байна. Энэ нь ургацын чанар, га-гаас авах ургацын хэмжээнд хөшүүрэг болж чадахгүй байна. Ийм учраас хөшүүрэг болохуйц цалингийн хэлбэр, урамшууллыг оновчтой хэрэглэх шаардлагатай.
- Газар тариалан нь байгалиас хамааралтай салбар тул ажиллагчдыг сургах, давтан сургах мэргэжилтэй ажилтан бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллахад төрийн зүгээс дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. ■

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг /ХХДХ/ тогтоохдоо бүс нутгаар ялгавартай тогтоовол ажилчид тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ. Энэ нь ялангуяа улирлын шинж чанартай ажил эрхэлдэг ажилчдад эерэг нөлөө үзүүлэх зорилготой.

Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн дундаж цалин нь хөдөө аж ахуйн салбарын ажилчдын дундаж цалингаас 8,6 мянган төгрөгөөр их, харин Сэлэнгэ аймгийн дундаж цалингаас 157,2 мянган төгрөгөөр бага байна.

3. Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд нь зөвхөн үндсэн ажилчдад НДШ төлдөг харин гэрээт ажилтан болон түр ажилчдад хувь хүний орлогын татвар төлдөг нь санхүүгийн тайлан /СТ-1, СТ-2/, нийгмийн даатгалын шимтгэлийн

УЛС ТӨР

ОРЧИН ҮЕИЙН УЛС ТӨРИЙН
НАМУУДЫН ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА

С.ЗУЛЬФИКАР

Удирдлагын академийн Улс төр судлал,
нийгмийн удирдлагын тэнхимийн эрхлэгч
доктор, дэд профессор/

Үргэлжлэл. Түрүүч нь №14 (072) дугаарт

Өргөн хүрээний нам хөгжих нөхцөл баруун Европ цаашлаад бусад улс оронд аяндаа төлөвшсөн үзэгдэл биш. Харин үүний эсрэгээр дараах хоёр хүчин зүйл онцгой үүрэгтэй байсан гэж ойлгож болно. Үүнд: 1) Улс төрийн намууд сонгуульд ялалт байгуулж, засгийн эрхийг авах, нэг бол засгийн эрх барихад идэвхтэй оролцох сонирхол нь улс төрийн намууд олон нийтэд нээлттэй нам болоход түлхэц өгсөн. 2) Сонгогчид мөн адил өөрсдийгөө ямар нэг улс төрийн үзэл санаа, үзэл баримтлалын салшгүй хэсэг гэж абсолют (туйлын) байдлаар ойлгохоос татгалзаж, иргэд, өөрийнх нь ашиг сонирхол, ямар ч нөхцөлд, ямар ч улс төрийн намаар дамжиж хэрэгжих бололцоотой гэж ойлгох болсон явдал юм. Нөгөө талаар өргөн хүрээний нам заавал олон гишүүн, дэмжигчтэй байна гэж хэт өрөөсгөл ойлгож болохгүй. Учир нь гишүүнчлэлд онцгойлон ач холбогдол өгдөг олон түмний намаас олон нийтийн дэмжлэг авахыг зорилго болгосон өргөн хүрээний нам ялгаатай юм.

Тухайн улс төрийн намын үзэл санаа, үзэл баримтлал нь нийгмийн бүхий

л хүрээг (ядахдаа дийлэнх хэсгийг) хамарсан шинжтэй бол өргөн хүрээний нам гэж ойлгож болох талтай. Гэхдээ мэдээж хөрөнгөтний эсвэл пролетарийн нам өргөн хүрээний нам болж чадахгүй нь улс төрийн үзэл баримтлалаас нь тодорхой ойлгогдоно. Эдгээр нам нь олон түмний нам болохыг өмнө тэмдэглэсэн билээ. Хэрэв гишүүд, дэмжигчдийн хүрээг шалгуур болгох аваас АНУ-ын Бүгд Найрамдах нам олон түмний намын хэв шинжийг илэрхийлэхгүй. Учир нь уг намд гишүүнчлэл чухал биш. Харин үүний эсрэгээр өргөн хүрээний шинжтэй кадрын нам гэж ойлгож болох талтай. Гэтэл Английн хөдөлмөрийн нам олон түмний намын шинжийг илэрхийлнэ. Учир нь үйлдвэрчний эвлэлийн гишүүд бараг автоматаар тус намын гишүүнчлэлтэй байдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд дан ганц ажилчин ангийг бус нийгмийн бүхий л хүрээг хамарсан үйлдвэрчний байгууллагаар дамжуулан гишүүд, дэмжигчдийн хүрээгээ тэлэх бодлого барьж байна. Иймд Английн Хөдөлмөрийн нам өргөн хүрээний нам болох чиг хандлага баримталж байна.

Баруун Европын намуудад бий болж байгаа өөрчлөлт, төлөвшил нь рационал хандлага, шинжлэх ухаан, мэдлэг боловсрол, технологийг намын байгуулалтын түвшинд болон улс төрийн үйл ажиллагаанд түлхүү нэвтрүүлэх хандлагыг илтгэх болжээ. Учир нь улс төрийн нам олон нийтийн хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээг агрегацилах чадвартай, түүнийг хэрэгжүүлэх мэдлэг, боловсрол, туршлага, зохион байгуулалт, хүний нөөцтэй байх шаардлага тавигдаж байгаа юм. Иймд баруун Европын намууд намын байгуулалтыг чадварлаг хүний нөөцөөр бүрдүүлэхийг чухалчилж байна. Ингэснээр нам

рационал улс төрийн бодлого тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх бодит бололцоо хангагдана гэж үзэх болжээ.

Скандиновын улс төр судлаачид К.Еласин, Л.Свэйсэнд нар улс төрийн намыг өвөрмөц байр сууринаас авч үзсэн байдаг. Тэд нам бол газар нутгийн нэгдэл, газар нутгийн тархалтаар үүссэн зохион байгуулалт гэж үздэг. Газар нутгийн нэгдэл нь тодорхой ашиг сонирхол, зорилго бүхий бүлэгт суурилан намын бүтэц, зохион байгуулалтын үндсийг тавьж, улмаар орон нутагт мөнхүү төвөөс хамааралтай бүтэц зохион байгуулалт тогтож, үндэсний түвшинд институцилагдсан улс төрийн нам бий болдог байна.

Финлянд, Швед, Норвегийн улс төрийн намын хөгжил, төлөвшлийг баруун Европтой адилтгаж болохоор байдаг. 1970-аад оны сүүл хүртэл намуудад манлайлал, хатуу гишүүнчлэл онцгой ач холбогдолтой байсан. Скандиновын намуудын хатуу гишүүнчлэл, үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан шатлан захирах бүтэц нь тэднийг баруун Европын улс төрийн намтай шууд адилтгаж байв. Намын төв аппарат, орон нутаг дахь салбар, удирдах зөвлөл гэсэн зохион байгуулалт тогтсон байх бөгөөд орон нутагтай холбоотой шийдвэрийг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа нэгжүүд, үндэсний түвшний бодлого шийдвэрийг намын төв аппарат, удирдах дээд байгууллага болох хурал гаргадаг байна. Аж үйлдвэржилт, хотжилт эрчимжиж, нийгмийг хамарсан томоохон өөрчлөлт бий болохын хэрээр улс төрийн намуудын зохион байгуулалт, үүрэг өөрчлөгдсөн. Скандиновын улс төрийн намууд 90-ээд оны сүүлээс өргөн ►►

▶ хүрээний намын зохион байгуулалт, үйл ажиллагааны хэв шинжийг эрэлхийлэх болжээ. Нийгэм, эдийн засгийн байдал сайжирч хүн амын амьдралын чанарын түвшин дээшилж, нийгмийн шинэ бүлгүүд бий болж, иргэдийн хүсэл сонирхол олон талтай болсон бөгөөд улс төрийн намууд мөн адил үүнтэй уялдсан уян хатан үнэт зүйл, хөтөлбөр санал болгож, зохион байгуулалт сонгож, үйл ажиллагаа явуулах шаардлага тавигдсан.

Скандиновын намууд нийгмийн бүлэг, иргэний нийгмийн сонирхлыг өөртөө нэгтгэхийг эрмэлзэх болжээ. Сонирхлын бүлгүүд улс төрийн үйл явцад шахалт үзүүлэх хандлага улс төрийн практикт нэвтэрч, намууд үүнийг ухаалгаар ашиглаж байна. Улс төрийн намуудын дэргэд залуучууд, эмэгтэйчүүд, ахмадууд, мэргэжлийн гэх мэт сонирхлын бүлэгт тулгуурласан иргэний нийгмийн байгууллага зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байна. Намуудын үзэл санаа, үзэл баримтлалын ялгаа багасч харин үүний эсрэгээр иргэний нийгмийн сонирхлыг нэгтгэсэн, түүнд чиглэсэн хөтөлбөрийг шалгуур болгосон үнэт зүйл, зохион байгуулалт, үйл ажиллагааны өөрчлөлт явагдаж байна.

90-ээд оны эхэнд коммунист дэглэм нуран унасны дараа ЗХУ, зүүн Европын социалист орнууд олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрч улмаар шинэ болон хуучин улс төрийн хүчнүүдийн хооронд улс төрийн өрсөлдөөн бүхий орчин бий болсон. Хуучин коммунист нам (пост-коммунист)-ууд нэг бол үзэл баримтлал, нэрээ өөрчлөх, эсхүл намаа бүхэлд нь татан буулгах, дахин шинээр байгуулах сорилттой тулгарсан. Улс төр судлаач Жон Ишияма пост-коммунист 16 улс төрийн намын улс төрийн амьдрал дахь мөчлөг, оролцоог өвөрмөц байдлаар судалсан үр дүнг доор хураангуйлан сийрүүлэе.

Ардчилсан шилжилтийн жилүүдэд пост-коммунист намууд засгийн эрх мэдлээ алдах үзэгдэл шилжилтийн улсуудад давхцсан байна. Харин сонгуулийн нэг мөчлөг өнгөрсний дараа пост-коммунист буюу тэдний суурин дээр шинээр болон

шинэчлэгдэн байгуулагдсан намууд улс төрийн үйл явцад идэвхтэй, амжилттай оролцож байв. Улс төр судлаачид үүнийг дараах хүчин зүйлтэй холбож тайлбарласан байна. Шилжилтийн явцад бий болсон нийгэм-эдийн засгийн хүндрэл нь иргэд хуучин дэглэмийн давуу талыг санагалзах (nostalgia) уур амьсгал бий болгосон. Нөгөө талаар эдгээр намууд нь үндэсний түвшинд зохион байгуулагдсан бүтэцтэй байсан. Хамгийн гол нь намын байгуулалтын чадавх, хүн хүч, хөрөнгө санхүүгийн хувьд давуу талтай байсан явдал юм. Үүний зэрэгцээ пост-коммунист намтай өрсөлдөхүйц зүүний чиг баримжаатай нам байхгүй байсан нь дэмжих хүчин зүйл болсон. Жон Ишияма пост-коммунист 16 улс төрийн намын зохион байгуулалт болон сонгуульд амжилттай оролцсон түвшний хамаарлыг персоны кореляцаар тооцож үзэхэд 0.76 буюу хүчтэй хамааралтай болох нь тогтоогдсон.

Эдгээр намууд нь социалист системтэй байх үед төрийн тогтолцооны цөм болж байсны дээр элитийн болон кадрын намын шинжтэй олон түмний намын хэв шинжийг түлхүү илэрхийлж байв. Сүүлийн жилүүдэд пост-коммунист намууд улс төрийн үйл явцад идэвхтэй, үр дүнтэй оролцох зорилгоор нийгмийн оюунлаг хэсэг, дундаж давхрааны төлөөллийг үйл ажиллагаандаа шууд татан оролцуулж байна. Учир нь нийгмийн дундаж давхрааг улс төрийн рационал шийдвэр гаргах эх сурвалж, чадавх гэж үзсэн байна. Энэ нь улс төрийн хүчний хувьд тодорхой амжилт үзүүлэх хүчин зүйл болсон.

Улс төрийн шилжилтээс хойш пост-коммунист улсуудад ардчилсан, либерал, үндэсний үзэлтэй намууд шинээр байгуулагдаж идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Хачирхалтай нь эдгээр намууд ч мөн адил олон түмний намын зохион байгуулалтыг сонгосон. Шинээр бий болсон намуудын тухайд гишүүнчлэл ач холбогдолоо бүрэн алдаагүй байна. Үүнийг урт хугацаанд хэвшин тогтсон хатуу гишүүнчлэлтэй болон кадрын намын соёлтой холбон ойлгож болох талтай. Нөгөө талаар шинээр байгуулагдсан улс төрийн намуудын

тухайд загвар, туршлага болгох ойрын болоод тодорхой жишээ нь пост-коммунист намууд байсан юм.

Монгол Улсад дээд шүүхэд бүртгэлтэй 22 улс төрийн нам байна. 2012 оны аравдугаар сарын 23-нд 22 дахь улс төрийн нам (Монголын Консерватив Нам)-ыг Улсын Дээд шүүх бүртгэжээ. Пост-коммунист орнуудад өрнөсөн улс төрийн үйл явцын нэгэн адил Монголд олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрснөөр барууны болон зүүний чиг баримжаатай улс төрийн хүчнүүд шинээр бий болсон. Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх, улс төрийн олон ургальч үзлийн үндсийг тавьж, нийгмийн харилцаанд төлөвшүүлэхэд улс төрийн намуудын үүрэг зайлшгүй байсан гэдэгтэй улс төр судлаачид санал нэгддэг.

Манай улс төрийн намуудыг зохион байгуулалтын хэв шинжээр нь эх газрын улс төрийн намын загварт багтааж болно. Үүний зэрэгцээ гол хоёр улс төрийн нам хатуу бүтэц, үндэсний түвшинд зохион байгуулагдсан олон түмний намын хэв шинжийг илэрхийлдэг. Гэхдээ МАН, АН-ыг эс тооцвол олон түмний намын хэв шинжтэй, гишүүнчлэлд тухайлан ач холбогдол өгч, үндэсний түвшинд зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа нам хараахан алга. Үүнийг улс төрийн намуудын хөрөнгө санхүү, хүний нөөцийн чадавхтай холбож ойлгох нь зүйтэй болов уу. Нөгөө талаар МАН, АН-ыг “кадрын”, “олон түмний”, “өргөн хүрээний” намын зарим хэв шинжийг агуулсан нам гэж үзэж болох юм. Учир нь энэ хоёр нам гишүүнчлэлд ач холбогдол өгөхийн зэрэгцээ нийгмийн бүхий л хүрээний дэмжлэгийг өөртөө татах мөрийн хөтөлбөр, үндэсний болон орон нутгийн түвшний зохион байгуулалт, хүний нөөц зэрэг шинж чанарыг хадгалж байна. Харин бусад намууд нь эрх зүйн хувьд нам байх шалгуурыг хангасан сонирхлын картел, кардын, хөтөлбөрт суурилсан, клейнт төвтэй намуудын хэв шинжийг илтгэдэг. Манай ихэнх улс төр судлаачид “Ардчиллын замаар хөгжиж буй улстай харьцуулахад улс төрийн хоёр голлох намын хүчтэй нөлөөлөл бүхий намын систем тогтож байгаа нь Монголын онцлог болж байна” гэж үздэг. ■

Үргэлжлэл бий